



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-49
<hr/>	
<i>1. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох</i>	6-34
<i>2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл сонсох</i>	34-46
<i>3. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /</i>	46-49

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
04 дүгээр сарын 11-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 20 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: Ц.Анандбазар, Г.Ганболд, Ж.Эрдэнэбат;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Наранбаатар.*

Нэг.Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтэн А.Молор, Монголын хөрөнгийн биржийн Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Х.Алтай, мөн компанийн Үйл ажиллагааны газрын захирал И.Жавхлан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, мөн газрын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын хэрэгжилтийн талаар Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл, Д.Батлут, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, “Эрдэнэс

Тавантолгой” хувьцаат компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ж.Батжаргал, О.Цогтгэрэл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Тогтоолын хэрэгжилтийн талаарх Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбатын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн үйл ажиллагааны талаарх Сангийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу, мөн компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од, Маркетинг, борлуулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Булган, Тээвэр, зохицуулалтын хэлтсийн дарга Н.Элдэв-Очир, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Х.Болортуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, мөн газрын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн үйл ажиллагааны талаар Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, С.Ганбаатар, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Аубакир, Д.Батлут нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн үйл ажиллагааны талаарх Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу, мөн компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од, Маркетинг, борлуулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Булган, Тээвэр, зохицуулалтын хэлтсийн дарга Н.Элдэв-Очир, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Х.Болортуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Т.Энхтүвшин “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Т.ЭНХТҮВШИН: 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Тогтоолд дараах агуулга бүхий 4 дэх заалтыг нэмэх:

Үнэт цаасны зах зээлийн байгууллагуудын бүтцийг цомхон болгох замаар хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлж, шимтгэл болон захиргааны зардлыг бууруулахыг дэмжих хүрээнд бодлого боловсруулж хэрэгжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	7
Бүгд:	11

36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Төслийн 1.4-т Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан стратегийн ордуудын тодорхой хувийг Монголын Хөрөнгийн биржээр арилжаалах хуулийн хэрэгжилтийг хангах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Т.Энхтүвшин: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 45 минут үргэлжилж, ирвэл зохих 18 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 17 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛГИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 14 цаг 20 минут.

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Т.Энхтүвшин: Байнгын хорооны хорооны гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг айлтгаж байна. Байнгын хорооны хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя. Г.Амартүвшин ирсэн байна. Т.Аубакир ирсэн байна. Ж.Батжаргал ирсэн байна. Д.Батлут ирсэн байна. Ж.Бат-Эрдэнэ ирсэн байна. С.Ганбаатар ирсэн байна. Ш.Раднаасэд ирсэн байна. Ц.Туваан ирсэн байна. Г.Тэмүүлэн ирсэн байна. Т.Энхтүвшин, Д.Өнөрболор гишүүн ирсэн байж байна.

Хуралдааны ирц 55.6 хувьтай учир хуралдаанаа эхлүүлэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 61.1 хувьтай бүрдсэн тулд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгд, Эрдэнэс Таван толгой компанийн үйл ажиллагааны талаар Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын мэдээллийг сонсох. Хоёрт, Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын тогтоолын хэрэгжилтийн талаар

Сангийн сайдын мэдээллийг сонсох. Гуравт, Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд Ж.Ганбаатар, Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эрдэнэс Таван толгой компанийн Хууль эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, Эрдэнэс Таван толгой компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу, Эрдэнэс Таван толгой компанийн Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Эрдэнэс Таван толгой компанийн Уул уурхайн технологийн газрын дарга Ч.Алтанбагана, Эрдэнэс Таван толгой компанийн Стратеги төлөвлөлт төслийн газрын дарга Ц.Анхбат, Эрдэнэс Таван толгой компанийн Маркетинг борлуулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Булган, Эрдэнэс Таван толгой компанийн Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Н.Элдэв-Очир, Эрдэнэс Таван толгой компанийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Х.Болортуяа ийм хүмүүс хуралдаанд оролцож байна. Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Бямбадагва Бямбадагва ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 113.1-д хуульд заасны дагуу эсхүл Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагын болон бусад

байгууллагын мэдээллийг хуралдаанаар хэлэлцэж болно гэж заасны дагуу Эрдэнэс Таван толгой компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсоно.

Мэдээллийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат танилцуулна. Ганбат даргыг урьж байна. Ганбат даргын микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Гишүүдийн өнөөдрийн амар амгаланг айлтгая. Ингээд Эрдэнэс Таван толгой компани дээр өнгөрсөн 2022 оны 10 сарын 26-ны өдрөөс эхлэн Засгийн газраас онцгой дэглэм тогтоож 6 сарын хугацаатай ингээд ажиллалаа. Энэ талаар ингээд мэдээллийг та бүхэнд танилцуулъя.

Компанийн ерөнхий мэдээлэл онцгой дэглэм тогтоох үеийн нөхцөл байдал ямархуу байсан. Нүүрсний асуудал, санхүүгийн асуудал, төсөл хөтөлбөрүүдийн асуудал, бусад асуудал тэгээд онцгой дэглэм тогтоосны үр дүн ямархуу байв гэдэг ийм байдлаар та бүгдэд товч мэдээлэл хүргэе.

Эрдэнэс Таван толгой компани нь энэ 2011 оноос борлуулалтаа хийж ирсэн нийтдээ 13 жилийн түүхтэй компани. Өнгөрсөн 2022 оны 10 сарын 26-ны өдрөөс онцгой хэрэг дэглэм тогтоосноос өнөөдрийн байдлаар Эрдэнэс Таван толгой компани 10.2 сая тонн нүүрс олборлож, 13 сая тонн нүүрс борлуулан, 4.3 их наяд төгрөгийн орлого олж төсөвт 1.5 их наяд төгрөгийн татварыг төлсөн. Ийм үр дүнтэйгээр ажиллаж ирлээ.

Онцгой дэглэм тогтоох буюу нөхцөл байдал ямархуу байв гэдгийг ингээд аваад үзэхэд, бид нүүрсийг хямдаар борлуулж байсан. Нүүрсний тээвэрлэлтийн хяналт сул, нүүрс

дутсан асуудлыг эцэслэн шийдвэрлэгддэг байсан. Хямд үнээр бартерын гэрээ байгуулдаг байсан гэдэг. Ийм Баруун цанхийн уулын ажлын гэрээ дуусгавар болж байсан. Ийм нөхцөл байдалтай яг нүүрсний үндсэн асуудал байсан.

Хоёрдугаарт санхүүгийн асуудлын хувьд, 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар урьдчилж орсон орлогын үлдэгдэл нь 582 сая ам.доллар байсан. Бонд болон бусад урт хугацаат өр төлбөрийн дүн, үүнээс үүдсэн өрийн дарамт өндөр. Энэ бонд урт. Бусад урт хугацаат өр төлбөрийн дүн 450 сая ам.доллар байсан. 2022 оныхоо төсвийг 1.7 их наяд төгрөгийн мөнгөн хөрөнгийн дутагдалтайгаар батлуулсан. Гэрээт олборлогчид өгөх өр төлбөр 123 тэрбум төгрөгийн ийм өр төлбөртэйгөөр санхүүгийн нөхцөл байдалд байсан. Төслүүдийн асуудал та бүгд мэдэж байгаа. Хэрэгжүүлж байгаа төслүүдийг нууцад хамааруулан шууд гэрээ байгуулдаг, төслүүдийн талаарх мэдээлэл ил тод бус байсан. Төслүүдийн гүйцэтгэл гэрээнээс хоцрогдолтой байсан. Тэгээд төслүүд нь санхүү хэт өндөр ачаалал үзүүлж байсан гэдэг ийм асуудал байсан.

Мөн төв оффисын ажилтны 25 хувь нь удирдах албан тушаал буюу дарга гэсэн нэртэй байсан. Тендерт сонгон шалгаруулалт шалгарсан компанитай шалтгаангүйгээр гэрээ байгууллагууд ингээд компаниудыг хохироодог ийм нөхцөл байдалтай төлбөрийн баталгаагүйгээр мөнгө шилжүүлдэг, мөн гэрээний хяналт сул гэдэг ийм байдалтайгаар онцгой дэглэм тогтоох үе нөхцөл байдал байсан. Ингээд 2022 оны 10 сарын 26-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд Засгийн газарт ингээд онцгой дэглэм тогтоосон энэ 5 сарын хугацаанд 1 тэрбум 260 буюу 6 сая долларын үнэлгээтэй ингээд 13 сая

тонн нүүрсийг борлуулсан. Энэ 5 сарын хугацаанд. Онцгой дэглэм тогтоохоос өмнөх үеийн дэглэм тогтоосноос хойших хугацааг харьцуулаад борлуулалтыг бид 4.1 дахин нэмэгдүүллээ. Нүүрс тээврийг 3.9 дахин нэмэгдүүлсэн, экспортыг 2 дахин нэмэгдүүлсэн, борлуулалтын орлогыг 3.9 дахин нэмэгдүүлсэн, олборлолтыг 2.7 дахин нэмэгдүүлээд бид нар 13 сая тонн нүүрсийг өнгөрсөн оны 10 сарын 26-наас энэ оны 3 сарын 31-ний хооронд 13 сая тонн нүүрс борлуулаад 1 тэрбум 260 сая ам.долларын борлуулалтын орлого орсон. Үүнээс яг бэлнээр дансандаа 755.6 сая ам.долларыг олсон. Мөн урьдчилж олсон орлого буюу өрийг бид нар 269.9 сая ам.доллаароор буурууллаа. Мөн оптик гэрээнд 208 сая ам.долларыг оптик гэрээнд төлсөн. Ийм дүнтэйгээр гол үндсэн үзүүлэлтүүдтэй ажиллаж ирлээ.

Нүүрсний асуудлуудыг шийдэх хүрээнд бид ямар ажлууд хийсэн юм гэх дээр Уул уурхайн сайд Уул уурхайн яам энэ дээр голлож анхаарал тавьж ажиллана. Бид нар нүүрсийг биржээр арилжих энэ арилжааг энэ онд амжилттай эхлүүлсэн. Монголын Хөрөнгийн биржтэй хамтран Монголын Хөрөнгийн биржээр дамжуулж нүүрсний нээлттэй цахим арилжааг нийт 7 удаагийн арилжаагаар бид нар 416000 тонн нүүрсийг 53.9 сая ам доллароор борлуулаад нэмэлт бид нар 20.9 сая ам доллароор нэмэлт орлого энэ биржээс олсон байгаа.

Хатуу коксжих нүүрсийг бид 244000 тонн хатуу коксжих нүүрсийг даан буюу ганц мод нөхцөлөөр борлуулаад үүнийг урьд нь уурхайн аман нөхцөлөөр 100-аас 115 ам.доллаароор борлуулдаг байсныг 55 хувиар нэмэгдүүлж, 178.6-аас 182.1 ам долларт хүргэж ингэж нээлттэй дуудлага худалдаагаар зарж чадсан.

Дараагийн асуудал нь бид нар эрчим хүчний нүүрсийг бид анх удаагаа энэ биржээр арилжиж үзсэн. Энэ дээр 192000 тонн эрчим хүчний нүүрсийг бас мөн ганц мод нөхцөлөөр уурхайн амыг 2020 онд 9 ам.доллаароор зардаг байсныг бид 8 дахин нэмэгдүүлээд 70.3-аас 73.3 ам.доллар нэг тонн нүүрсийг ингэж анх удаагаа эрчим хүчний нүүрсийг арилжиж ингэж үзсэн. Одоо бид нэг юман дээр хагас коксжих нүүрсээ цахим арилжааг бас зохион байгуулах гээд энэ 4 сарын 14-ний өдөр зохион байгуулахаар ингэж арилжиж байгаа. Тэгэхээр энэ дээр бид өнгөрсөн 12 жилийн хугацаанд түүхэндээ энэ хагас коксжих нүүрс гээд үүнийг сул коксожсон гэж бас нэрлэдэг юм байна билээ. Ерөөсөө л 212000 тонныг зарж байсан. Эндээс бид энэ оны 2023 оны төлөвлөгөө бид ТҮЗ-өөр батлуулсан. 23.9 сая тонн нүүрс олборлож борлуулах ийм төлөвлөгөөтэй байгаа. Үүнээс бид нар 30 хувийг нь Хөрөнгийн биржээр цахим арилжаагаар байгаагаар зарах ийм зорилт тавьж байгаа.

Нөгөө талдаа бид Эрдэнэс Таван толгой компаниа сорчлох гэдэг ийм ойлголтоос бүрэн татгалзах ёстой. Олборлосон бүх төрлийн бүтээгдэхүүн буюу хатуу коксжих, хагас коксжих эрчим хүчний нүүрсээ бүгдийг нь борлуулж ингэж орлого олно гэдэг ийм байдлаараа явна гэдэг энэ дээрээ хатуу зорилтоо тавьж байгаа. Мөн цахим арилжаагаар бид 30 хувиа арилжих юм бол, энэ онд 7.2 сая тонн нүүрс борлуулах юм бол бид өнөөдрийн ханиаар тооцвол 241.4 орчим сая ам доллар нэмэлт орлого олох юм байна гэдэг ийм байдлаар тооцож төлөвлөж ажиллаж байгаа.

Нүүрсийг хил нөхцөлөөр борлуулсантай холбоотой бид өөрсдөө тээврээ Ганц модны боомт дээр хүргэж өгч байгаа. Нүүрсний тээврийг бид төрийн худалдан авах агентлагтай

хамтран зохион байгуулаад, нүүрс тээврийн зохион байгуулалтыг сайжруулж, тээврийн компаниудын үйл ажиллагааг дэмжсэнээр бид Монголдоо тээврийн компаниудын төлөх татварын орлого нь үлдэх ийм нөхцөлийг бүрдүүлж өгсөн байгаа. Нийтдээ бид тендерийг дотоодын компаниуд дээр 1 сараас эхэлж зарласан 2 үе шаттайгаар. Тэгээд 10 чиглэлийн 23 багц тендер зарласнаас 218 аж ахуйн нэгж оролцож, 317 тендерийн санал ирүүлж, шаардлага хангасан 176, тендерийн санал ирүүлсэн 122 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулан, тээврийг ингэж хийгээд байна.

Бид биржийн нүүрсээс 416 мянгаасаа бид нар 3 сарын 3-наас эхэлж тээврээ эхлүүлсэн. Энэ эхлэлтийг 12 компанийн 363 тээврийн хэрэгслээр 96000 тонн нүүрсийг Ганц мод боомт дээр хүргэж өгсөн байгаа. Бид тээврийг нээлттэй сонгон шалгаруулалт зарласнаараа бид тээврийн дундаж үнэ 1 тонн нүүрсийг 59309 төгрөгөөр бид тээвэрлэж байгаа. Төсөвт өртөг нь 126 мянга 927 гээд байгаа. Үүнээс бид 6.4 тэрбум төгрөгийн сонгон шалгаруулалт тээврийн энэ зардал хэмнэж байгаа. Эндээс нэг ийм тоо харагдаж байгаа. Бид тээврийн компаниуд 2021 онд зөвхөн Эрдэнэс Таван толгой компанид тээвр хийдэг байсан компанид 2021 онд 29.8 тэрбум төгрөг төлдөг байсан бол 2022 оны жилийн эцсээр нийт дүндээ 97.1 гээд сая 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 76.7 тэрбум төгрөг тээврийн компаниуд төлсөн байгаа. Эндээс бид энэ тээврээ бид Эрдэнэс Таван толгой компани өөрсдөө хийдэг болсноороо тээврийн компаниудын төлөх татвар орлого нь Монгол Улсад үлдэж байгаа юм байна гэдгийг энэ тоогоороо бид нотолж харуулж байгаа юм.

Бид Эрдэнэс Таван толгой компани дээр онцгой дэглэм тогтоох үед орон нутгийн Таван толгой

компанитай нөгөө мөргөцөг алга болсон асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байсан. Энэ асуудлыг өнгөрсөн 2022 оны 12 сарын 27-ны өдөр 258.9 мянган тонн нүүрсний төлбөр болох нийт 13.9 сая ам.доллар буюу 48 тэрбум төгрөгийг Эрдэнэс Таван толгой компанид орон нутгийн Таван толгойгоос бүрэн шилжүүлж барагдуулж, энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн байгаа. Нийтдээ Эрдэнэс Таван толгой компани дээр онцгой дэглэм тогтоох үед 10 сарын 26-ны өдрийн байдлаар 178 борлуулалтын гэрээ байсан. Үүнээс уурхайн ам нөхцөлтэй 133 гэрээ, Гашиунсухайт нөхцөлтэй 7 гэрээ, оптик 4 гэрээ нь дотроо дэд гэрээтэй гээд 38 гэрээ, дотроо нөгөө Таван толгой, Гашиунсухайт төмөр зам, Богд Хаант төмөр зам, Нүүрс баяжуулах үйлдвэр, Газрын тосны хийн хоолой гэдэг ийм гэрээнүүдтэй үндсэн 178 гэрээтэй 10 сарын 26-нд байсан. Үүнийг бид сая 2023 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар 101 борлуулалтын гэрээ болсон. Үүнээс 133 уурхайн ам нөхцөлийг бид хугацаа нь дууссан. Хугацаа нь дууссан гэрээг бүгдийг нь дуусгавар болгосон. Хугацаа нь дуусаагүй гэрээнүүд дээр бид үүнийг Ганц мод боомт руу буюу хил нөхцөл рүү шилжүүлээд 87 гэрээ болгож өөрчилсөн байгаа.

Мөн тэр уурхайн ам нөхцөлийн 11 гэрээ гээд оптик гэрээ уурхайн ам нөхцөлтэй 3 гэрээ байгаа. Энэ дээр Таван толгой, Гашиунсухайт төмөр зам дээр оптик гэрээ 27 дэд гэрээ ингээд коксжихоос эрчим хүчний 18 гэрээ болсноос үүнийг 3 сарын 31-ний өдрөөр энэ ам нөхцөлтэй гэрээг дуусгавар болгоод, яг энд Таван толгой, Гашиунсухайт төмөр зам дээр оптик гэрээ болох 1 гэрээ үлдсэн байгаа. Энэ бол үлдэгдэл нь 4.3 сая тонн, энэ 2024 оны 12 сарын хугацаанд дуусна. Гэхдээ энэ бол төмөр замын ажил нь хийгдээд дуусахад бүрэн бололцоотой. Тэгээд

Богд хаант төмөр замыг бол бүрэн зогсоосон байгаа.

Мөн нүүрс баяжуулах үйлдвэр, газрын тосны хийн хоолой дамжуулах тийм оптик гэрээнүүд үргэлжилж байгаа. Бид 87 гэрээг ганц мод нөхцөлөөр буюу хил нөхцөлөөр шилжүүлснээр бид нар 300 орчим сая ам.долларын орлого олох ийм боломжийг бүрдүүлж ингэж хангаж ажилласан. Уулын ажлын гэрээт хүчний сонгон шалгаруулалт гээд Цанхийн баруун уурхайн 3 жилийн хугацаатай гэрээний хугацаа 2023 оны 3 дугаар сард дуусгавар болсонтой холбогдуулан сонгон шалгаруулалтыг зарласан. Энэ сонгон шалгаруулалтыг зарлахад бид үүнээс өмнөх 3 жилийн хугацаанд 1 метр куб хөрс хуулалтыг уулын ажлыг 12945 төгрөгөөр хийдэг байсныг бид 11500 төгрөгөөр бууруулсан. Өрөмдлөг тэсэлгээг 2000 төгрөгөөр метр куб нь хийдэг байсныг 1890 болгосон. Нүүрс ачилтыг 1763 төгрөгөөр тонныг нь хийдэг байсныг бид нар 1645 гээд, нийтдээ яг энэ тендерээс бид 254.9 тэрбум төгрөгийг хэмнэж ажиллахаар ингэж гэрээ нь дуусгавар болсон ажлуудын сонгон шалгаруулалтыг нь зохион байгуулсан.

Санхүүгийн асуудлуудыг ишийдвэрлэх хүрээнд онцгой дэглэм тогтоохоос өмнө Эрдэнэс Таван толгой компани дээр урьдчилж олсон яг энэ 2022 оны 2, 3 сард урьдчилж 603 сая ам.доллар олсон юм байна билээ. Яг 10 сарын 26-нд 582 сая долларын үлдэгдэлтэй байсан. Үүнийг энэ оны 3 сарын 31-ний байдлаар бууруулж 286.4 сая ам.долларт хүргэсэн. Урт хугацаат өр төлбөрөөс 450 сая ам.доллароос бид нар 2023 онд 4 сарын 7-ны өдөр төлбөр болгох 236.5 тэрбум төгрөг, 39 сая ам.долларыг амжилттай төлж, өөрийн эргэлтийн хөрөнгөөсөө болон борлуулалтын орлогоос төлж барагдуулсан байгаа.

Өнгөрсөн 2022 оны төсвөө 1.7 их наяд төгрөгийн алдагдалтай буюу мөнгөн хөрөнгийн дутагдалтай батлагдсаныг 2022 оны жилийн эцсээр 385 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг нь нэмэх эерэг үлдэгдэлтэй ингэж гаргасан байгаа. Гэрээт олборлогчид онцгой дэглэм тогтооход 123 тэрбум төгрөгийн өр байсан. Энэ өөрөөр хэлбэл, 2021 оны 9 дүгээр сараас хойш хуримтлагдсан өр төлбөрүүдийг өнгөрсөн 2022 оны 11, 12 сарын дотор бүрэн барагдуулж, энэ компаниудын гэрээт ажлын гүйцэтгэлийг нь санхүүжүүлж ажилласан.

Төсөл хөтөлбөрүүдийн дараагийн танилцуулах асуудал байгаа. Нийтдээ яг тэнд өмнө нь би үүнийг нэлээн ярьчихсан учраас энэ дээр нууцаас Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 449 тоот тогтоолоор Эрдэнэс Таван толгой компани дээр нууцын зэрэглэлтэй байсан гэрээг бүгдийг нь ил болгоод, өөрийн цахим хуудсаараа үүнийг бүгдийг нь ил болгосон байгаа. Үүн дээр Таван толгой, Гашиунсухайт чиглэлийн төмөр замын санхүүжилт болон төлбөрийг нүүрсээр барагдуулах нийт 2 гэрээ байгаа. Богд хаант төмөр зам дээр 3 гэрээ байгаа. Мөн өөрийн төсөлтэй холбоотой Загийн усны хоолой болон далд уурхай бас энэ дээр бас нууцын байдалтай байсан. Үүнийг бүгдийг нь ил болгосон байгаа, 11 сарын 8-нд. Одоо бол Эрдэнэс Таван толгой компани дээр нууцын зэрэглэлтэй гэрээ байхгүй. Бүгдийг нь ил болгосон. Энэ компани дээр нийтдээ 11 төслийг санхүүжүүлж байна. Үүнээс яг өөрийн үндсэн Эрдэнэс Таван толгой компанийн уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл бол энэ уурхайн тоног төхөөрөмж байна. Ул ил уурхайн конверын систем гэдэг ийм 2 төсөл байна. Ажил нь 30 хувьтай, нөгөөдөх нь 5 хувьтай байгаа ингэж явж байгаа.

Дараагийнх нь нэмүү өртөг шинэчилсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох зорилгоор 4 төсөл байгаа. Энэ бол нүүрс баяжуулах үйлдвэр, загийн усны хоолойн гүний ус ашиглах төсөл, газрын тос дамжуулах хоолой, Таван толгойн дулааны станц.

Дараагийнх нь зардал бууруулахтай холбоотой төмөр замын нийтдээ 5 гэрээ гээд байгаа. Энэ төслүүдээс Богд хаант төмөр замыг явуулсан. Бусад нь ингээд ажлууд нь, төмөр замын ажил бол Таван толгой, Зүүнбаян төмөр зам 98 хувьтай бусад ажлууд ерөнхийдөө санхүүжигдээд явж байгаа. Нийт 4.9 тэрбум ам.долларын төсөвт өртөг нийт 11 төслөөс 1.5 тэрбум ам.долларыг санхүүжүүлээд байгаа. Гэрээний хугацааны хувьд зарим нэгэн хоцрогдолтой, хугацааны хувьд шахаж ингэж ажиллаж байгаа. Төслүүд ингээд яг үндсэн 11 төслүүдийг санхүүжүүлж ажиллаж байна. Нүүрс баяжуулах буюу нүүрс угаах үйлдвэрийг энэ Эрдэнэс Таван толгой компани дээр хэрэгжүүлээд явж байгаа. Энэ 10 сая тонн нүүрс угаах хүчин чадалтай. Ингээд энэ үүнийгээ дагалдуулаад бид 12.1 километр урттай нүүрсний конверын системийг дамжуулан уурхайгаас түүхий эд татах байдлаар үүнийг ашиглалтад оруулна. Мөн Таван толгой дулааны станц гэдэг ийм байдлаар явж байгаа.

Хэрвээ энэ баяжуулах үйлдвэрийг бид нар яаралтай аль болох яг графикаараа 2024 оны 6 сард ашиглалтад орно. Хугацааны хувьд бид үүнийг шахаж явж байгаа. Одоогийн байдлаар, бид яг энэ баяжуулах үйлдвэр ороод 10 сая тонн нүүрс угааж, энэ үйлдвэр ашиглалтад орох юм бид нар тонн тутмаас нь 60-80 ам.доллар нэмэлт орлого олох ийм боломжтой байгаа юм. Энэ уурхайгаас конверын системээр бид баяжуулах үйлдвэр рүүгээ нүүрсээ татахаар ингэж

төлөвлөж энэ дээр ажиллаж байгаа. Энэ дээр тээврийн зардал буурна, бас байгаль орчинд ашигтай гээд. Энэ дээр ийм тоо байгаа. Гишүүд үүнийг бас анхаараач. Нийт төсөвт өртөг нь 192 тэрбум байгаа. Бид хэрвээ үүнийг конверын систем нэвтрүүлэхгүйгээр авто тээврээр тээвэрлэх юм бол 1 тонн ачааг 24.3 мянган төгрөгөөр тээвэрлэнэ. Конверыг ашиглалтад оруулах юм бол 1 тонн ачааг 3.7 мянган төгрөгөөр тээвэрлэх ийм боломж бүрдэнэ.

Бусад асуудлын хувьд, компанийн бүтцийг оновчтой болгох ажлын хүрээнд шаардлагагүй алба нэгжийг татан буулгаж, удирдах ажилтны тоог бууруулж ингэж ажилласан. Тэгээд өнгөрсөн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэнтэй холбоотой олборлолтыг 118 хувь, борлуулалтын төлөвлөгөө 124 хувь, цэвэр ашиг нь 156 хувьтай гарсан учраас нийт уурхайн ажилтан, 1 компанийн ажилтны үр дүнгийн урамшуулал 13 дахь сарын цалин, үндсэн цалинг 40 хүртэл хувиар нэмэгдүүлэх ийм шийдвэрийг оны өмнө гаргаж ингэж ажилласан байгаа.

Нийтдээ төлбөрийг баталгаагүйгээр мөнгө шилжүүлэх оролдлого хийсэн, мөн шалгарсан компанитай шалтгаангүйгээр гэрээ байгуулаагүй албан ёсны гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн, компанид мэдэгдэлгүй тусгай зөвшөөрөлтэй талбайд газар орсон, талбайгаас нүүрс дутсан зэрэг асуудалтай холбогдуулан 9 албан хаагч, 6 хуулийн этгээд, 1 асуудлыг Авлигатай тэмцэх газарт 16 өргөдөл, гомдол хүргүүлсэн. Эрүүгийн цагдаагийн газарт 5 албан бичгээр бас мөн хандаж хууль хяналтын байгууллагад хууль зөрчсөн асуудлыг шалгуулж, ингэж ажиллаж байгаа.

Саяын 11 төслөөс гадна Эрдэнэс Таван толгой компаниас нийтдээ 1.2 их наяд төгрөгийн дараах төслүүдийг санхүүжүүлэх байдлаар олгосон. Үүнд, Таван толгой түлш компани дээр 845 тэрбум төгрөг санхүүжүүлж олгосон. Уурхайн үйл ажиллагаатай холбоотой төслүүд дээр яг энэ өөрийн холбоотой, энэ дээр 173.5 тэрбум олгосон. Багануур, Шивээ-Овоод ер нь зээл олгож авдаг юм байна билээ. Энэ өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой. Үүнд 49.5 тэрбум олгосон. Мөн Таван толгойн бүлэг ордын харуул хамгаалалтыг дотоодын цэргийн хамгаалалтад оруулсантай холбоотой 30.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлж байна. Тэрбум мод төслийн хүрээнд 28.3 тэрбум төгрөг, мөн Өмнөговь аймгийн онцгой байдлын газарт нөгөө ковидын үед хамтарч ажиллах хүрээндээ 3.9 тэрбум төгрөг гээд ийм ажлуудыг санхүүжүүлж, мөн далд уурхайн хайгуул шинжилгээний санхүүжилт, Бор тээгийн уурхайн төсөл гэдэг ийм төслүүдийг санхүүжүүлэх хүрээнд 1.2 их наяд төгрөгийг мөн санхүүжүүлж ирсэн ийм үр дүнтэй ажилласан.

Ингээд онцгой дэглэм тогтоосноос хойших энэ 5 сарын хугацаанд би үүнийг түрүүнд хэлчихсэн байгаа. Нийтдээ 5 сарын хугацаанд 1.3 тэрбум ам.долларын үнэлгээтэй бид 13 сая тонн нүүрсийг борлуулж ирж, үүнээс яг бэлэн дансанд 755.6 сая ам.доллар, тэгээд урьдчилсан орлогыг 269.6-гаар бууруулсан оптек гэрээний төлбөрт 208 сая ам.долларыг өгч, ингэж үр дүнтэй ажиллаж ирсэн.

Өнгөрсөн оны өмнө 2 сарын хугацаанд бид нар бэлэн 416 сая ам.доллар оруулсан. Үүнээс урьдчилж төлсөн орлогыг 155.5 сая ам.доллароор бууруулж ингэж ажилласан. Төлөвлөгөөг бид 500 сая байсан гүйцэтгэлээр 588.8 саяын төлөвлөгөөг давуулж ингэж ажилласан байгаа.

Өнгөрсөн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар төлөвлөсөн цэвэр ашгийг 56 хувиар давуулан биелүүлж 1.3 их наяд төгрөгийн буюу 37 хувийн цэвэр ашгийн түвшинтэй ажилласан байгаа. Энэ асуудал аудитад ороод дуусаад, аудитын тайлан ингэж гарсан. 2022 оны жилийн эцсийн тайлангаар.

Энэ 2023 оны эхний 3 сарын байдлаар бид 765.2 сая ам.долларын үнэлгээтэй, 7.5 сая тонн нүүрс борлуулсан. Үүнээс 416000 тонныг нь биржээр борлуулсан. Үүнээс бид нар дансандаа 445.6 сая ам.долларыг бэлэн оруулсан. Урьдчилж орсон орлогыг 169.2 сая ам.доллароор бууруулсан. Оптек гэрээнд 150.4 сая ам долларыг санхүүжилт өгсөн байгаа. Тэгээд мөн дансандаа орж ирсэн 445.6 сая ам.долларыг төвлөрүүлснээс Эрдэнэс Таван толгой бондын 110 орчим сая ам. долларыг үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийг өөрсдөө ингээд төлсөн байгаа. Мөн худалдан авагчдын төлөх өр төлбөрийг мөн 169.2 ам.доллароор бууруулж, 284,6 сая ам.доллар болсон. 7 удаагийн биржийн арилжааг амжилттай зохион байгуулж, 416000 тонн нүүрсийг биржээр хил нөхцөлтэй ингэж амжилттай зохион байгуулж ажилласан. Ийм үр дүнтэй ажиллалаа. Танилцуулж дууслаа.

Т.Энхтүвшин: Ганбат даргад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүнд микрофон өгье.

Т.Аубакир: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Засгийн газраас шийдвэр гаргаад Эрдэнэс Таван толгой болон Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулахтай холбоотой маш олон арга хэмжээ аваад ажиллаад явсны нэг нь бол энэ Эрдэнэс Таван толгой дээр

томилогдсон БЭТ, дотоод үйл ажиллагааг цэгцлэх ажил байсан. Мааш амжилттай явж байгаа гэж харж байгаа юм.

Биржээр дамжуулан нүүрсийг борлуулаад Монгол Улсын эдийн засагт бас тодорхой хэмжээний өөрчлөлтүүд, сайн зүйлүүд гарч ирж байна. Энэ асуудлыг Уул, уурхайн яам оруулж ирээд, богино хугацаанд ингээд шийдвэрлээд явж байгаад бас талархал илэрхийлэх ёстой. Өнөөдөр төгрөгийн хани тодорхой хэмжээнд чангарсан, валютын урсгал нэмэгдсэн байдалтай ийм байж байгаа.

Тийм учраас эхний асуулт, Эрдэнэс Таван толгой дээр замбараагүй байсан үүнийг цэгцлээд явж байгаа, ингээд дундаас нь орхиод хаячих биш, цаашаагаа ер нь БЭТ-ийн хугацааг би 4 сарын 20-нд дуусна гэж ойлгож байгаа. Миний хувьд бол БЭТ-ийг цаашаа үргэлжлүүлээд, тодорхой хэмжээнд цэгцлэх бас ажлууд бий. Тийм учраас БЭТ-ийг цааш нь үргэлжлүүлээд ажиллах бодолтой байгаа юу, Уул, уурхайн сайд Ганбаатараас асууя.

Бүрэн эрхт төлөөлөгчөөс ганц, нэг асуулт байгаа. Түрүүн та хэллээ, тээврийн асуудлыг бас тендерээр үндсэндээ сонгон шалгаруулалтаар зохицуулаад явж байгаа гэж. 59000 төгрөг тонн тутамд гэсэн тийм ээ, сая. Энэ маань яг хажууд зэрэгцээд ажиллаж байгаа хувийн хэвшлийн мөн адилхан Энержи Ресурсес гэдэг юм уу, адилхан газар зайнд тээвэр хийж байгаа хувийн компанийн тээврийн зардалтай харьцуулахад ер нь хямдхан байж чадаж байгаа юу. Энэ дээрээ судалгаа хийсэн үү. Өмнө нь бид нар ойлгохдоо хувийн компани хямдхан тээврээ хийж болоод байдаг. Гэтэл энэ төрийн өмчит компани нь хэд дахин илүү үнэтэй тээвэрлэдэг байсан явдал дээр та цэг тавьж чадсан уу гэж, эхний асуулт.

Хоёр дахь асуулт, БЭТ-ээс, энэ тээврээ бас арилжаалагдсан нүүрстэйгээ уялдуулаад зохицуулж чадаж байгаа юу. Яагаад гэвэл орон нутгийн Таван толгой дээр бас алдаа гараад эхэллээ шүү дээ. Биржээр нүүрсээ арилжаалчихдаг, тохирсон, хэлэлцсэн хугацаандаа хүргэж өгч чадахгүй асуудлууд гарч байна. Энэ маань эргээд энэ нүүрсний арилжааг бирж рүү авчирсан дээр дахиад доголдол гараад ирэх вий. Жижиг Таван толгой нэг тиймэрхүү байдалтай болчихсон явж байгаа. Ухаандаа хятадууд маань арилжаанд ороод нүүрсээ авчихсан байдаг. Тохирсон хэлэлцсэн хугацаандаа хүргэж өгч чадахгүй ийм байдал үүсээд байгаа юм. Энэ, энэ тэр дээрээ анхаараад, тээврээ, нүүрснийхээ арилжаатай уялдуулаад явуулахад асуудал тулгарахгүй биз дээ гэсэн ийм асуултууд байгаа юм.

Би эхний асуултыг Ганбаатар гишүүнээс асуудаг нь, энэ дээр бас яг тээвэртэй холбоотой байдаг ч юм уу, нүүрсийг сорчлохгүй байх, мөн компанийн засаглалыг сайжруулахтай холбоотой, ер нь БЭТ-ээ тодорхой хугацаанд хугацаанд сунгаад ажиллах нь зөв гэж үзэж байгаа юм. Ийм 3 асуулт байна. Эхнийх нь Ганбаатар сайдаас, дараагийнх нь бүрэн эрхт төлөөлөгчөөс асууж байгаа юм.

Т.Энхтүвшин: Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Аубакир гишүүнд баярлалаа. БЭТ-ийн хугацаа дуусаж байгаа, үнэн. Тэгээд цаашаа 6 сараар сунгахаар болж байгаа. Тэгэхдээ Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэнэ. Амарбаясгалан сайд, Сангийн сайд бид нар бас зөвшилцөөд 6 сараар Ганбат БЭТ-г сунгана гэсэн ийм асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж байгаа. Энд хариулт ойлгомжтой байх гэж бодогдож байна.

Ер нь Ганбат БЭТ-ийн хувьд сайн ажиллаж байгаа, маш сайн ажиллаж байгаа. Цаашидаа хийх ёстой нэг зүйл байгаа. Байнгын хорооны хурал дээр хэлье. Энэ нүүрсээ тогтмол борлуулах, ялангуяа биржээр борлуулах ажил дээр худалдан авагч талтай гэрээ хэлцлүүдийг сайжруулах талаар Уул, уурхайн яам шууд удирдлагаар хангадаггүй, бодлогоор хангадаг. Тэгэхээр үүнийг сайжруулах талаар санал санаачилгатай, Уул, уурхайн яамтай сая бас шинэ Боомтын сайд томилогдож байх шиг байна. Тэгээд энэ сайдтай хамтраад энэ нүүрсийг тогтмол авч байгаа урт хугацаанд их авах сонирхолтой болоод, тэр биржээр авах сонирхолтой айлуудаа ангилж, ялгаад ингээд явах нь таны ирээдүй б сард хийх ёстой ажлуудын гол ажил гэдгийг Байнгын хорооны хурал дээр Их Хурлын гишүүний хувиар хэлчихье. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Дараагийн асуултууд хэн хариулах юм. 2 номер.

Н.Цэрэнсамбуу: Эрдэнэс Таван толгой компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Цэрэнсамбуу Аубакир гишүүний асуултад хариулъя. Бид нар хил нөхцөлтэй худалдаалж байгаа нүүрсний тээвэрлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн ерөнхий гэрээний сонгон шалгаруулалтын журмаар зохион байгуулж байгаа. Яагаад энэ журмаар зохион байгуулах болсон бэ гэхээр, нэгэнт энд нүүрсний тээвэртэй холбоотой маш их хэмжээний аж ахуйн нэгжүүд, тээврийн хэрэгслүүд бий болчихсон байсан. Ийм учраас яг тээвэр хийж байгаа аж ахуйн нэгжүүдийн оролцоог жигд хангах үүднээс 10 чиглэлд, 23 багц болгоод аж ахуйн нэгжийн хүчин чадлыг нь тээврийн

стандартад нийцүүлээд 21 машин, 50 машин, 100 машинаар тухайлсан чиглэлүүдэд нүүрс тээвэрлэнэ гэсэн багцлалтаар ерөнхий гэрээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.

Ерөнхий гэрээний сонгон шалгаруулалтын арга нь энгийн нээлттэй тендертэй харьцуулахад чадавхын шаардлага хангаж байгаа хэдэн ч этгээдтэй гэрээ байгуулах боломжтой. Тухайн хэрэгцээ шаардлага нь бий болсон даруйд 30000 тонн нүүрсийг 4 сарын 15-ны дотор Ганц мод боомтод хүргэж өгнө гэдэг захиалгаа өгөөд тухайн багцад шалгарсан аж ахуйн нэгжүүд нэгж үнээрээ үнийн саналаа ирүүлж өрсөлдөх ийм эрүүл тогтолцоо руу шилжүүлсэн. Ингэж зарлахдаа бол бид нар нэгж үнийн дээд хязгаарыг тогтоосон. Нэгж үнийн дээд хязгаарыг тогтоохдоо бол Зам, тээврийн хөгжлийн сайдын жишиг тариф, мөн тээвэртэй холбоотой бусад нэмэлт зардлуудыг тооцох зарчмаар гаргасан. Тухайлбал, Гашиун сухайт чингэлэг тээврийн терминалаас Ганц мод чиглэлд 55000, уурхайгаас Гашиунсухайт чингэлэг тээврийн терминалд 107000 гэсэн дээд хязгаарыг тогтоосон. Гэхдээ бодит гүйцэтгэл ямар явцтай явж байгаа вэ гэхээр нөгөө өрсөлдөх тэгш боломжийг бий болгоод, гарааны нэг цэг рүү оруулаад ирэхээр үнэ яг бодитой нөхцөл байдал руугаа орж байна. Тухайлбал, уртын тээвэр 50000 орчимд, богинын тээвэр дээр бол дунджаар 11000, хамгийн хямдхандаа 5000, хамгийн их өндөр дүнтэй нь 1 тонныг нь 21000-аар тээвэрлэж байгаа. Энэ нь яг одоогийн ам нөхцөлтэй худалдаалж байгаа тээврийн үнэ ханшитай харьцуулах юм бол нэлээн бага байна. Ялангуяа богинын тээвэр дээр бол сая 3 сарын эхээр 1 тонн нүүрс нь 500 юань, өнөөдөр бол 200 орчим юаниар зөөж байгаа. Энержи ресурсес компани бол бидэнд ирүүлсэн мэдээллээр бол 110-аас 120 юаниар уртын тээвэрээ хийдэг.

Сая бас энэ тээврийн үнэ хани бас хятад талын худалдан авагчид өөрсдөө тээврийг бууруулж байгаатай холбоотойгоор 95 юань орчимд тээврээ хийж байгаа гэсэн мэдээлэл ирүүлсэн.

Товчхондоо бол яг энэ бусад худалдан авагчийн, бусад 2 уурхайн тээврийн үнэтэй харьцуулахад Эрдэнэс Таван толгой компанийн биржээр хил нөхцөлтэй Ганц мод боомтод хүргэж өгч байгаа тээвэрлэлтийн үнэ хани бол хямдхан явж байгаа. Гэхдээ мэдээж холбогдох хууль тогтоомж буюу Зам, тээврийн сайдын баталсан жишиг тариф, норм энэ дүрэм, журамдаа нийцээд ажиллаж байгаа гэж хэлье. Хариулж дууслаа.

Т.Энхтүвшин: 3 дахь асуудал байсан уу.

Н.Цэрэнсамбуу: Хугацааны хувьд яг одоогийн байдлаар бид нар 2 гэрээнийхээ нүүрсийг бүрэн хүргээд өгчихсөн. Дараагийн 2 гэрээний тээвэрлэлт бол ингээд энэ 7 хоногтоо дуусахаар байгаа. Тэгэхээр яг хуваарийнхаа дагуу тээвэрлэлтийн үйл ажиллагаа явагдаж байгаа. Биржээр арилжаалахдаа тэдэн сарын тэдний өдөр нүүрсээ хүргэж өгнө гэдэг хугацаагаа тавьж байгаа. Энэ биржийн гэрээ амжилттай болоод гэрээ нь хийгдсэний дараа бид нар тээврийн хоёр дахь шатны сонгон шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны цахим систем дээр хийгээд, шалгарсан тээвэрлэгч нь 21 эсхүл 50 гэсэн машиныхаа тоогоор машинаа гаргаад, хуваарийн дагуу тээвэрлэлтээ хийж байна. Ер нь ам нөхцөлтэй хийгдэж байгаа тээвэрлэлт дээр 1 машин 10 хоног хүлээж байгаад 1 удаа хил нэвтэрдэг байсан бол биржийн тээвэрлэлт бол богино эргэлтээр бага үнийн дүнгээр буюу нэгж.

Т.Энхтүвшин: Аубакир гишүүн тодруулъя.

Т.Аубакир: Баярлалаа. Тэгээд БЭТ томилогдсоноос хойшоо Эрдэнэс Таван толгой бас бас хурдтай урагшилж байгаа. Бас нэг санаа зовох ёстой асуудал бол Ганбат дарга аа, энэ 1072 хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг Эрдэнэс Таван толгой дээрээ бий болгох. Хувьцаа өгсөн нэртэй байгаад байдаг, 18 хувь байдаг байх аа. Тэд нарын төлөөлөл ерөөсөө байхгүй. ТУЗ-ийг сая яах вэ, сүүлд Засгийн газраас нэлээн цэгцлээд тоог нь багасгаад явуулъя гэж байна. Гэхдээ яг классик утгаараа бол хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл ТУЗ-ийг бүрдүүлэх ёстой шүү дээ. Энэ бол бас амаргүй ажил. Энэ дээрээ бас бүрэн эрхт төлөөлөгч маань энэ хугацаа сунгаад ажиллаж байгаа бол энэ дээр бас анхаараад явах нь зөв байх. Энэ цаашидаа яг бид нарын Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж байгаа энэ шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ТУЗ-д нь хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл байхгүй байна гэдэг чинь яг нөгөө классик утга руугаа очихгүй байгаа шүү дээ. Амаргүй ажил. Гэхдээ бид хэд бас энэ асуудлыг захъя гэж бодож байна. Санал хэллээ.

Т.Энхтүвшин: Санал байлаа. Батжаргал гишүүн баярлалаа.

Ж.Батжаргал: Тэгэхээр Эрдэнэс Таван толгой дээр энэ онцгой дэглэм тогтоогоод бүрэн эрхт төлөөлөгч томилоод, дотоод ажлын зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, тээвэрлэлтийн асуудлууд дээр хяналт нэлээн сайжирч, энэ хэмжээгээр үр дүнгүүд нэлээн ахиутай гарсан байна. Тийм учраас энэ бүрэн эрхт төлөөлөгч түүний багт талархал илэрхийлэх ёстой гэж ингэж ойлгож байна. Яадаг ч байсан бүрэн эрхт төлөөлөгчийнхөө бүрэн эрхийг хэрэгжүүлэх хугацааг сунгах юм уу, үүнээс доргүй менежментийг бүрдүүлж

энэ уул, уурхайн компанийг авч явах юм уу гэдэг асуудал бидэнд байгаа. Үүнийхээ судалгаа юмнуудыг Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам нэлээн нарийн судлаад, тэгээд Засгийн газартаа мэдээж асуудлаа танилцуулж шийдэл юмнууд нь гарах болов уу гэсэн ийм бодолтой байна.

Бидний яг энэ явсан цаг хугацаа сая энэ Уул уурхайн биржийн тухай хууль батлагдаад, хэрэгжих хугацаанаас нь өмнө тодорхой хэмжээний туршилтын борлуулалтуудыг хийе гэдэг үүднээс зохион байгуулалт авагдсан. Энэ нэлээн гайгүй үр дүн, нэг тийм боломжит загваруудыг туршиллагуудыг бий болгож байх шиг байна. Ямар ч байсан коксжсон нүүрсний үнэ 72 доллар 55 орчим хувиар өссөн, тэр эрчим хүчний нүүрс 8 дахин буюу 61 доллароор өссөн гээд нэгж тутамдаа нэлээн сайн үзүүлэлтүүд гарч байна. Тэгэхээр үүнийг дагуулж бүтээгдэхүүний чанар стандартын асуудлыг сайжруулах, тодорхой болгох, худалдан авч байгаа тал ямар ч эргэлзээгүй болох тал дээр бид нэлээн их юм хийх шаардлага байгаад байх шиг байгаа юм. Энэ дээр ер нь ямар ажил, юу хийж байгаа юм бэ гэж.

Хоёрдугаарт, тээвэр ложистикийнхоо асуудлыг бид бүрэн шийдсэн байх ёстой. 7 сарын 1-нээс шиг санаад байна. Би хууль бүрэн хэрэгжээд эхлэхээр ер нь уул уурхайн бүтээгдэхүүнүүд биржээр худалдаалагдах ёстой. Түүнээс өмнө энэ үлдсэн хугацаанд бид тэр тавьж байгаа экспортын хүрэх түвшинээ хангах түвшинд яаж нэвтрүүлэх чадвар тээврийнхээ асуудлыг шийдэж чадах вэ гэдэг юмаа ер нь ямархуу байдлаар зохицуулж, ямар арга хэмжээ авах гэж байна вэ гэдэг асуудал.

Нэгэнт биржээр бараа бүтээгдэхүүнээ борлуулахаар нэг

тодорхой хилийн үнэ тогтчихлоо, бид бүгдэд. Тэгвэл биржээр борлогдоогүй байгаа бүтээгдэхүүнийг бид яаж энэ хилийн биржийн үнийн рүү дөхүүлэх вэ гэдэг талаар ер нь ямар бодлого чиглэл байна вэ? Хууль хэрэгжтэл бид чинь 30 орчим хувийн ч билүү туршилтаар ингээд хийгээд явъя гэдэг ийм чиглэл бодлого барьцаасан. Тэгвэл цаад үлдэж байгаа 70 хувиа өмнөх үнээрээ зарж болохгүй байлгүй дээ энэ чинь. Тэгэхээр зэрэг энэ рүү бид ямар худалдан авагч талтайгаа хэлцэл юмнуудаа хийж байгаа вэ. Нэгэнт борлуулж байгаа жишиг үнэ тогтоож байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ дээр ер нь ямар зохион байгуулалтын чиг хандлагууд байна вэ гэж.

Өөрийн өртгийг хямдруулах тал дээр нэлээн анхаарал хандуулж ажиллаж байгаа юм байна. Худалдан авах ажиллагааны асуудал дээр нэлээн төвлөрч уулын ажлынхаа чиглэл дээр нэгж тутамдаа 1445 төгрөгөөр хямдруулж чадсан байна. Өрөмдлөгийн ажил дээрээ 110 төгрөгөөр бууруулж чадсан байна. Тэгээд үүнийг цааш нь бид тогтвортой барьж ажиллах тухай асуудал. Дээр нь энэ өөрийн өртгийг хямдруулах чиглэл дээр бүтцийн асуудал, бусад туслан гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулах үйл явцууд, худалдан авалтын бүхий л үйл ажиллагаануудыг ил тод нээлттэй шалгаруулах замаар зохион байгуулж байж, энэ үр дүнд хүрнэ.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүнд нэмж 1 минут өгье.

Ж.Батжаргал: Энэ хэмжээгээр ашиг, үр өгөөж нэмэгдэх ёстой. Энэ рүүгээ бид гол анхаарлаа төвлөрүүлж ажиллах ёстой юм гэж.

Хэрэгжүүлж байгаа төслүүдийг харсан. Уул уурхайн үндсэн үйл ажиллагаатай холбоогүй нэлээн олон

төслүүд хэрэгжээд байна. Энэ яг нарийндаа бас ингээд шийдчихдэг зүйл биш шүү. Үнэнийг хэлэхэд. Наад компани гэж байгуулсан юм тэр компанийнхаа засаглалд, тэр хуулийнхаа хүрээнд энэ асуудал зохицуулагдаж явах ёстой. Үүнийгээ бид бодож, зөв эрх зүйн зохицуулалтынх нь түвшинд бодлого чиглэлээ тодорхойлж авч явахгүй болохгүй. Таван толгой түлшийн асуудал, тэр 2 уурхайн өвлийн бэлтгэл хангахад гаргаж байгаа мөнгө эд нар чинь гардаг мөнгө мөн үү гээд бодох юмнууд зөндөө байна. Үүнийг бодох ёстой. Дээр нь 1.3 их наядын ашигтай гарчээ. Ашигтай гарсан юм ард түмэнд тодорхой хэмжээний хувьцаа.

Т.Энхтүвшин: Ганбаатар сайд хариулъя. Ганбаатар сайдын микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбаатар: Тэр чанар стандартын хувьд ер нь намайг сайд болохоос өмнө ер нь 3 стандарттай ер нь удаан хугацаанд явчихсан юм байна билээ. Сөрөг үр дагаврууд нь нэлээн их. Уурхайнуудад Аубакир гишүүн түрүүн асуусан. Тэр сорчлон ашиглах энэ байдал хэтэрхий давамгайлсан. Тэгээд тэр 3 стандартаасаа Сангийн яам өндөр үнээр АМНАТ авчихдаг. Энэ асуудлуудыг 195 дугаар тогтоол гэдгийг Засгийн газрын хуралдаанаар батлуулаад, энэ батлуулсан тогтоолын дагуу 29 стандарттай болсон байгаа. Энэ 29 стандартынхаа дагуу энэ бол голлож ямар ач холбогдолтой вэ гэвэл, түрүүний таны хэлээд өнгөрдөг, тэр эрчим хүчний нүүрс гарах боломжууд нь нээгдсэн байгаа юм. Тэгээд энэ 29 стандарт гэдэг нь, тэр нь маш олон стандарттай болж байгаа. Тэр хэмжээгээрээ энэ стандартын нүүрснүүдийг худалдан борлуулах боломжтой болсон гэсэн үг. Тэгээд энэ стандартаар гаргасан нүүрснийх нь дагуу АМНАТ тооцож авдаг ийм болж байгаа. Тэгэхлээр энэ хувийн ч бай, улсын

ч бай уурхайнууд зөвхөн сайн чанарын нүүрсээ л гаргадаг сонирхолтой байсан бол одоо холиод тэр эрчим хүчний нүүрсээ зүгээр нэг овоолоод байх биш, чанар арай бага нүүрснүүдээ ч гэсэн гаргах энэ бололцоонууд нь бүрэн нээгдсэн гэдгийг хэлье.

Та бас түрүүн тэр ашигт ажиллагааны хувьд мэдээж БЭТ 6 сараар сунгагдчихаад, цаашаа бид Засгийн газраас ямар менежмент явуулах вэ гэдгийгээ урьдчилаад ярилцаж байгаа. Тэгэхдээ одоохондоо хараахандаа зарлах хэмжээнд хүрээгүй байна. Тэгээд хэнд, яаж, ямар менежментээр даатгах вэ, цааш нь яаж явуулах вэ гэдэг талаар. Тэгэхлээр хамгийн гол барьж байгаа зүйл энэ компанийн үр ашгийг дээшлүүлэх. Энэ зүйлийг л дараагийн менежментийн багт тавина. Үр ашгийг дээшлүүлэх гэхлээр ашгийг дээшлүүлэх. Түүнээс биш олсон орлогоороо баахан төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд, зардлаа орлоготойгоо мөргүүлчихдэг ийм юм байж болохгүй. Хувьцаат компани бол хувьцаа нь өсөх ёстой. Сая Батжаргал гишүүний минут нь дуусаад, тэр үр ашиг гээд ярилаа. Тэгэхдээ, үр ашгийн хувьд хэлэхэд энэ компани хэдийгээр ашигтай ажиллаж байгаа ч гэсэн бараг 4 их наядын өртэй байгаа юм. Тэгээд энэ өрөө шийдвэрлэх ёстой. Үр ашгаа дээшлүүлэх ёстой. Хөндлөнгөөс Уул уурхайн яам гэдэг юм уу, Засгийн газраас оролцоод заавал түүнийг тараах ёстой эсхүл ингэх ёстой гэсэн байдлаар оролцохгүй байгаа. ТУЗ нь өөрсдөө шийдвэрлэх хэрэгтэй. Тэгээд ийм байдлыг барьж байгаа гэдгийг хэлье. Миний хариулт дууслаа.

Т.Энхтүвшин: БЭТ. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ер нь яг өнөөдрийг хүртэл явж ирсэн асуудал

дээр нүүрсний чанарын асуудал нэлээн яригдаж байгаа юм. Одоо яг үндсэн олборлолт нь Баруун, зүүн Цанхиас нүүрс олборлоно. Тэгэхдээ бараг бүх худалдан авагч нар зүүн Цанхиас нүүрс авна гэдэг, баруун Цанхийн хувьд чанарын асуудал яригддаг. Тэгэхээр одоо яг үүнийг бид чанар дээрээ онцгой анхаараад, чанарыг шийдэх ганц арга бол бид угаах үйлдвэрийг яаралтай ашиглалтад оруулах гэдэг энэ байдлаар угаах үйлдвэрийн төсөл ингээд 40 гаруй хувийн гүйцэтгэлтэй явж байгаа. Үүнийг яг графикаар 2024 оны 6 сард ашиглалтад оруулна. Гүйцэтгэгч компанийг аль болох хугацааны хувьд 1 өдрийн өмнө ч гэсэн наашаа оруулаач гэдэг ийм байдлаар шахаж байгаа. Энэ бол 10 сая тонн нүүрс угаах хүчин чадалтай ийм үйлдвэр ашиглалтад орно. Усны төсөл нь амжилттай явж байгаа. Энэ байдлаар чанарыг бид шийдээд явах бололцоотой.

Нөгөө талдаа ер нь Эрдэнэс Таван толгой компани нь 13 жилийн түүхэнд дандаа нөгөө хатуу сайн чанарын коксжих сайн чанарын нүүрсээ зарж ирсэн. Бид үүнийг сорчлохгүй гэж байгаа. Яг уулын ажлынх нь төлөвлөгөө нь ингээд юмнуудыг нь үзэхээр, бид нар нөгөө сул коксжсон нүүрс гэж байна, эрчим хүчний нүүрс байна. Энэ хоёрыг бид овоолго үүсгэж хаяхгүйгээр зардаг болж байж, энэ компани ашигтай ажиллана. Тэгэхээр бид нар энэ эрчим хүч, сул кокс, энэ сайн чанарын нүүрснүүдийг бид маш сайн уялдааг нь хангаж, ингэж сорчилно гэдэг ойлголтыг ер нь гаргахгүйгээр ингэж явдаг. Мөн бүтээгдэхүүнээ бас зах зээл дээр таниулдаг, мөн худалдан авагч нарт энэ талаар бас ойлголт өгдөг, сурталчилдаг энэ талд нь түлхүү анхаарч ажил ажиллахаар ингэж төлөвлөж байгаа.

Нөгөө талдаа таны хэлсэн яг үндсэн үйл ажиллагаатай хамаарахгүй

төслүүдийг санхүүжүүлж ирсэн юм бол байна. Жишээ нь Багануур, Шивээ-Овоо гээд адилхан нүүрсний уурхай. Гэхдээ өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд сүүлийн нэлээн хэдэн жил энэ компанид дандаа энэ хоёрт зээл гэдэг нэрээр мөнгө өгч байсан. Тэгээд бид үүнийг зогсоох талаар Эрдэнэс Монгол компанитай ярилцаж байгаа. Энэ компани хоёр Багануур, Шивээ-Овоо бол бие дааж үйл ажиллагаа явуулах бүрэн бололцоотой. Энэ талд нь боломжийг нь хангаж ажилла гээд бид үндсэн нүүрс олборлолт, борлуулалтын компани болохоос биш бид зээлүүд компани биш гэдэг ийм байдлаар ажиллаж байгаа юм.

Нөгөө талдаа энэ Таван толгой түлшний асуудал байна. Энэ асуудлыг бид бас ингээд Эрдэнэс Таван толгой компани ингээд өнөөдрийг хүртэл байгуулснаас 800 гаруй 900-гаад тэрбум төгрөгийн санхүүжилт олгочихсон. Үүнийг цаашидаа яаж авч явах вэ. 100 хувь Эрдэнэс Таван толгой компаниас хамааралтай ажиллаж байгаа. Тэгэхээр энэ Таван толгой түлшний асуудлыг яах вэ гээд гэх мэтчилэн асуудлуудыг нь эрэмбэлээд ингээд яг цэвэр өөрийн нэмүү өртөг шингээх, яг үндсэн ашгаа нэмэгдүүлэх энэ төслүүд дээр түлхүү анхаарах чиглэлээр тээвэрлэлтийн зардлаа бууруулах, энэ талдаа түлхүү анхаарах нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг бас компанийн зүгээс болон Засгийн газрын түвшинд барьж эрэмбэлэх ингэж анхаарч ажиллаж байгаа.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм. Ер нь энэ төрийн өмчтэй компаниудаа олон нийтийн засаглалтай болгох тухай асуудал ч ярьцаагаад байгаа юм. Ер нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, өмчит компаниудын тухай

хуулийг бид яаралтай оруулж ирж энэ удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын эрх хэмжээ, чиг үүргийг ч их тодорхой болгох, энэ үйл ажиллагаанд сая энэ БЭТ дээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудыг шинээр энэ хуулийн зохицуулалт дотор оруулж ирж зохицуулалтыг нь сайжруулах тухай ч асуудал. Дээр нь ашиг гэж үнэхээрийн юм гарч байгаа хэдэн хувь нь тэр үйлдвэр хөгжүүлэх үйл ажиллагаандаа зарцуулагдаж, хэдэн хувь нь энэ хувьцаа эзэмшигч нартаа хувьцаа болж явах ёстой юм бэ гэдэг юмыг тов тодорхой болгож өгөхгүй байгаагаас болоод үндсэндээ дур зоргын юм шиг юм болж хувираад байгаа юм. Уг нь энэ компанийн хуулиар ашигтай л гарсан юм бол ноогддог хувь хэмжээ.

Т.Энхтүвшин: Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Түрүүн тэр Батжаргал гишүүн нэг чухал зүйл хөндсөн. Тэр биржээр зарагдаж байгаа нүүрснээс хямд үнэтэй гэрээ хийхгүй байгаа биз дээ гэж. Тэгэхлээр манай Уул, уурхайн яамны бодлого бол Ганбат БЭТ дур мэдэж гэрээ хийхгүй. Хэрвээ нүүрс зарах гэж байгаа биржээрээ л зарна. Урт хугацааны хуучин гэрээнүүдийг зарж байгаа. Гэхдээ Уул, уурхайн яамнаас ямар шаардлага хүргүүлж байгаа вэ гэвэл, хуучин гэрээнүүдийнхээ хэлэлцээний ард суугаад 70 доллар, 80 доллар байгаа наадхаа биржийн үнэ рүү дөхүүл гэдэг энэ шаардлагыг тавьж байгаа юм. Тэр 170 руу очуул гэж. Тэр хувьцааны хувьд Ганбат дарга хариулчих нь зөв байх гэж бодож байна.

Т.Энхтүвшин: Ганбат дарга, ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Би тэр Батжаргал гишүүний түрүүнд, сая Ганбаатар сайдын хэлсэн Эрдэнэс Таван толгой

компани 10 сарын 25-нд онцгой дэглэм тогтоосон. Шинээр ам нөхцөлтэй шинээр гэрээ байгуулаагүй. Уурхайн ам нөхцөлтэй 133 гэрээ байсныг нь бид хугацаа нь дуусгавар болсныг нь дуусгаад, хугацаа нь болоогүй гэрээнүүдийг хил нөхцөл рүү шилжүүлэх хүрээнд 133 ам нөхцөлтэй гэрээг 87-г нь бид нар ганц мод нөхцөлөөр хил нөхцөл рүү шилжүүлсэн. Бусад томоохон худалдан авагч нарт бас мөн хил нөхцөл рүү шилжүүлэх саналыг удаа дараа тавиад хэлэлцээр хийж байгаа. Тэгэх дээр бид саяын 133 гэрээг 87 ам хил нөхцөлтэй болгож өөрчилснөөр яг одоогийн үнээрээ явбал бид нар 300 орчим сая ам.доллар нэмэлт орлого олох ийм боломж байна гэдэг ийм байдлаар. Ер нь ямар нэгэн ам нөхцөлтэй гэрээ болон хил нөхцөлтэй гэрээг шинээр огт байгуулаагүй. Ам нөхцөлийг бид хил нөхцөл рүү шилжүүлэх ийм байдлаар.

Т.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбат БЭТ ажиллаад бас тайлангаа тавьж байна. Нэлээдгүй амжилттай үйл ажиллагаа явуулсан гэж үзэж байгаа тайланг харахад. Тэгэхээр энэ уул уурхайн биржийн тухай хууль батлагдсан. Ёндон сайдын үед өргөн баригдаад, Ганбаатар сайд өөрөө Байнгын хорооны дарга байхдаа үүнийг өлгийдөж аваад ажлын хэсэг бид гаргаад ингээд ажилласан шүү дээ. Энэ бол үр дүнгээ өгч байгаа. Өөрөөр хэлбэл, Байнгын хороонд байхын нэлээн ач холбогдол өгнө гэж байсан. Үнэхээр өнөөдөр ач холбогдол өгчихлөө шүү дээ. Энэ 224000 тонн коксжих нүүрсийг даан нөхцөлөөр, ганц мод нөхцөлөөр жишээ нь урьд өмнө бол 100-115 доллароор зарж байсан бол одоо 55 хувь нэмэгдээд, 178.6-аас 182.1 мянган доллароор зарж байгаа юм байна шүү дээ. Энэ бол 55 хувьтай бол энэ маш ач холбогдол өгч байна. Тэгэхээр яг үүнтэй холбоотойгоор, сая

өөрөө хэллээ. Дахиж гэрээ хийхгүй. Тийм үү. Фючер худалдаа тэр ирээдүйн нөгөө том гэрээнүүд хийгдээд тэр гэрээний дагуу худалдаалах юмнууд явах ёстой шүү дээ, уг нь биржээрээ тийм үү. Одоохондоо тэр гэрээ хийгдэхгүй гэж байгаа юм. Гэхдээ энэ 7 сарын 1-нээс нөгөө Биржийн тухай хууль маань хүчин төгөлдөр болсон хойно бол яг хуулиараа явчих юм байгаа биз дээ, тийм үү. Энэ дээр та хариулт өгөөрэй гэж нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сая Батжаргал гишүүн чинь яриад байна. Бид нар уул уурхайн биржийн тухай хуулиа батлахдаа дагалдсан Улсын Их Хурлын тогтоол баталсан юм шүү дээ. Тэгээд энэ тогтоол дээр бид нар нөгөө менежментийг сайжруулъя. Нээлттэй болгоё, нээлттэй хувьцаат компани болгоё гэсэн нэг зүйл яригдсан тийм үү. Үүнийг бид нар нөгөө Улсын Их Хурлын тогтоолынхоо хэрэгжилт дээр ер нь Засгийн хэзээ оруулж ирэх юм. Хэзээ яаж үзэх юм гэдэг асуудал дээр нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яг энэ дээр нөгөө 1072 хувьцаагаа бид нар эргэлтэд оруулъя гэсэн шүү дээ. Нөгөө 2000 оноос, 2012 оноос хойш төрсөн сая орчим хүүхдүүд байгаа. Тэд нартаа хэзээ оруулж ирэх юм, хэзээнээс тэд нартаа хувьцаа олгох юм, хэдэн хувийн хувьцаа гаргах юм нэгдүгээрт. Хоёрдугаарт, эргэлтэд орвол энэ менежменттэй холбоотой асуудлууд маань хэзээ яг шийдэгдэх юм гэсэн ийм асуудлууд.

Гуравдугаарт, ер нь бол бид нарт хувьцаа болоод ирэх ёстой юу, ноогдол ашиг болоод ирэх ёстой байсан, ард иргэдэд ирэх ёстой байсан мөнгийг ер нь бол хөрөнгө оруулалт болон төмөр зам руу оруулчихсан байгаа. Тэгэхээр төмөр замд орсон энэ ард иргэд авах ёстой байсан ноогдол ашгийг нөхөж олгоё

гэсэн нэг ийм санааг энэ тогтоол дээрээ бол тусгасан шүү дээ. Нөхөж олгох ёстой гээд. Тэгээд энэ дээр Засгийн газар ер нь яаж харж байгаа вэ? Хэзээгээр олгох боломж бололцоо байна. Энэ санхүү эдийн засгийн тооцоо чадвар чадавч чинь ямаршуу байгаа юм. Хэдэн оноос эхлээд бид нар үүнийг нөхөн олгох юм уу, олгох ийм боломж бололцоо байна уу гэсэн ийм зүйлүүд байгаа.

Дөрөвдүгээрт, Ганбатаас нэг зүйлийг асуугаадахъя. Энэ хөрөнгө оруулалтууд маань, одоо угаах үйлдвэрүүд дээр 40 хувийн хөрөнгө оруулалт гүйцэтгэлтэй явагдаж байна гэж байгаа юм байна. Дээрээс нь миний мэдэхийн энд нөгөө конвер эд нар хийе гэсэн хөрөнгө оруулалтууд яригдаж байх ёстой тийм үү. Энэ дээр ямар хэмжээний хөрөнгө оруулалт, өөр ямар, ямар хөрөнгө оруулалтууд байна. Товчхон хэдий хэмжээний хөрөнгө хэрэгтэйгээс хэдийг нь та нийлүүлэх бололцоотой байна. Бүтэн 100 хувь санхүүжүүлэх бололцоотой байна уу, эсхүл цаашаагаа энэ санхүүжүүлэх хугацаа чинь магадгүй өшөө 24, 5 руу сунгаж байж нөгөө борлуулалттайгаа нэмэгдэхээр байна уу, эсхүл өсөн нэмэгдэж байгаа борлуулалттайгаа харьцаад наана нь энэ хөрөнгө оруулалтаа бүгдийг нь хийх боломж бололцоо байна уу гэсэн дээр тайлбар өгөөч ээ гэж.

Тэгээд бас нэг санал хэлэхэд, Ганбаатар сайд бид нөгөө нэг энэ шинэчлэл явагдчихлаа. Энд. Одоо БЭТ очоод том шинэчлэл хийлээ. Цааш цаашидаа дахиад л шинэчлэлээ, ингээд БЭТ-ийг сунгаад л ингээд айлгаж, ичээгээд ингээд яваад байх юм уу, эсхүл яг номоор нь явдаг.

Т.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүнд нэмээд 1 минут өгөөдхөөрэй.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгээд миний хэлэх гээд байгаа зүйл бол БЭТ-г дахиад нэг сунгачихъя гэж байгаа юм байна. Яах вэ энэ хугацаанд үйл ажиллагаагаа жигдрүүлбэ гэж бодож байгаа байх л даа. Гэхдээ минийхээр бол сонгон шалгаруулах яг ирээдүйн ямар хүн ажиллах юм, ямар мэргэжилтэй, боловсролтой, туршилагатай тэгээд ямар чадвартай менежер тавьж байж ажиллах. Энэ нь нөгөө БЭТ- гэдгээр айлгаж, ичээгээд нөгөөдөх нь номоороо явдаг биш. Ерөөсөө анхнаасаа менежер нь очоод номоороо явдаг нээлттэй байх, түүнийг та бүхэн харж хянаж чаддаг байх. Бид бол үндсэндээ зүгээр сургаараа яваад байгаа шүү дээ. Одоо тэгсэн юм гэнэ, ийм гэрээ байдаг юм гэнэ билээ гэж байгаа болохоос бид мэдээлэлгүй. Яам бас тэр хэмжээний мэдээлэлтэй байж бас чадаж байна уу, үгүй юу, хамтарч ажиллаж хяналтаа тавьж чадаж байна уу, үгүй юу? Тэгээд хэзээ буцаад яг жинхэнэ менежерээ томилоод явах юм бэ гэсэн ийм асуулт байгаа шүү.

Т.Энхтүвшин: Ганбаатар сайд:

Ж.Ганбаатар: Одоо бол яг бирж түр ажиллаж байгаа. Түр журмаар ажиллаж байгаа. 7 сарын 1-нээс хууль хэрэгжинэ. Та Эдийн засгийн байнгын хороонд өөрөө баталсан учраас маш сайн мэдэж байна. Тэгэхээр одоо богино хугацааны хэлцэл буюу форвард хэлцлийг түр журмаар хийгээд нүүрсээ нийлүүлж байгаа. Ойролцоогоор сая орчим тонн нүүрс биржээр зарагдсан байгаа юм. Зарим хүмүүс яах вэ биржийг жаахан буруу харуулах гэдэг юм уу, яадаг юм. 178-аар дуудаад 180 хүрсэн байна ч гэдэг юм уу эсхүл 3 харилцагч оролцоо гэдэг юм уу, иймэрхүү үг өгүүлбэрүүд явдаг юм. Тэгэхдээ та их голыг нь хэллээ шүү дээ. 100 доллар байсан, 80 доллар, 90 доллар байсан нүүрсийг бид хамгийн багадаа 170 долларт аваачсан. Энэ өөрөө бид

нарын хувьд түр журмаар явж байгаагийн хувьд том амжилт гэж харж байгаа юм.

Тэгээд сая БЭТ Ганбат дарга хэлж байна. Бид шинэ гэрээ байгуулахгүй, хэрэв байгуулах нь гэсэн тохиолдолд 170-аас доошоо үнээр байгуулахгүй шүү дээ. Тэр урт хугацааны дандаа богино гэрээ байгуулаад байх юм уу, урт хугацааны гээд хуульд чинь байгаа шүү дээ. Яг тийм ээ, 7 сарын 1-нээс эхлээд урт хугацааны гэрээнүүдийг биржээр байгуулаад, бирж яг үйл ажиллагаа нь эхлээд явна. Одоо энэ Хөрөнгийн биржийн захирал байгаа байх. Тэгэхлээр Хөрөнгийн биржийн захирлын талаар тодорхой хариулт өгөх бүрэн боломжтой. Одоо бол бид зөвхөн богино хугацаат гэрээ хийж байгаа. Мөнгөө 100 хувь урьдчилж авч байгаа. 7 сарын 1-нээс эхлээд тодорхой журмуудыг хуулийг дагуу батлуулах ёстой, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Уул, уурхайн яам энэ журмуудынхаа дагуу тэгээд бүх хэлцлүүдээр гэрээ хийгээд явах бүрэн боломжтой гэж 1 дүгээр асуултын хувьд.

Гуравдугаар асуултын хувьд, мэдээж 6 сарын дараа ингээд дахиад БЭТ-ийг сунгаад байхгүй. Энэ БЭТ хийх ёстой юмаа хийлгэнэ. Тэгээд таны хэлж байгаа үнэхээр яг энэ нээлттэй, тэгээд менежментийн баг очиж энэ ажлыг цааш нь үргэлжлүүлэн авч явах ёстой. Гэхдээ энэ хувьцаатай холбоотой асуудал дээр хэлэхэд, бид энэ компанийг бас дотоод асуудлуудаа бүрэн шийдэг. Өөрсдөө саналаа гарга гэж хүлээж байгаа Засгийн газар. Ялангуяа Уул, уурхайн яам. Түүнээс биш дөнгөж оччихонгуут нь тэр мөнгийг тийшиээгээ хувьцаанд өг, энэ мөнгийг ийш нь явуул гэсэн байдлаар Засгийн газраас ийм тогтоол ч гэдэг юм уу, ийм зүйлүүдээр би ялангуяа БЭТ бол ямар ч байсан

дотоод асуудлаа цэгцлээд сайн, муугаа ялгаад, тэгээд энэ компанийг хөл дээр нь гэх юм уу даа, ядаж өлмийн дээр нь ч юм уу зогсоох, энэ боломжийг энэ БЭТ энэ удирдлагуудад нь гаргаж өгч байгаа. Тэгээд бүрэн өөрийнхөө боломжоор ажиллаад, тэгээд ТУЗ нь өөрсдөө хуралдаад, өөрсдөө шийдвэрүүдээ гаргадаг энэ компанийнхаа зарчимд ороосой гэж Засгийн газар, Уул, уурхайн яамнаас хүсэж байгаа гэдгийг хэлье. Ер нь тэгэхдээ хүлээлт иргэдийн хувьд болоод нийгэмд өндөр байгааг бид ойлгож байгаа. Энэ компани тодорхой хэмжээнд ашигтай ажиллаж байгаа. Олон зүйлүүд рүү бас буруу хөрөнгө оруулалтууд өмнө нь орсон. Тэр хөрөнгө оруулалтууд нь үр өгөөжөө бас богино хугацаандаа өгөхгүй байгаа. Урт хугацаандаа ч өгөх тийм зүйлүүд нь бас өнцөг нь харагдахгүй байгаа зүйлүүд ч байна. 3 асуултад хариулчихсан гэж ойлгож байна. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Би нэмэлтээр товчхон Батэрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ Эрдэнэс Таван толгой компани дээр 2022 оны 7 сараас эхэлсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл хэрэгжиж байгаа. Энэ бол яг гэрээнийхээ хугацаагаар 2024 оны 6 сард ингээд дуусах ийм төлөвлөгөөтэй байгаа. Энэ 10 сая тонн нүүрс баяжуулах ийм зориулалттай байгаа. Мөн усны төсөл байгаа, үүнтэй уялдаатай. Тэгэхлээр бид үүнийг яаралтай ашиглалтад оруулах хэрэгтэй байгаа юм. Үүнийг оруулж байж бид өөрөөр хэлбэл, дахиад 60-80 долларыг бид нэмэлт орлого олох боломж байгаа, энэ угаах үйлдвэр. Энэ цэвэр. Тэгэхдээ үүний тулд энэ төслүүд дээр сая тэр 1072 хувьцаатай холбоотой асуудал босож ирээд байгаа юм. Бид 1.3 их наядын 2022 онд ашигтай ажилласан. Энэ компанийн 18.4 хувийг 2012 оны 4

сараас өмнө төрсөн 2.5 сая иргэд эзэмшиж байгаа. Тэгэхээр бид 18.4 хувь эзэмшиж байгаа хүмүүсүүддээ ноогдол ашиг гэж өгөх үү. Өмнө нь 2019 онд 1 удаа тараасан юм байна билээ. 1 хүнд 96000 төгрөг өгсөн. Түүний дараа ковидын 2020, 21 оны асуудал яг ингээд үзэхээр бид 100000 орчим төгрөг тараах нь зөв үү. Бид яаралтай энэ угаах үйлдвэрээ ашиглалтад оруулахад нэмэлт хөрөнгө оруулалтаа хийгээд бид 60-80 долларын нэмэлт орлого олох уу гэдэг ийм сонголт хийх ёстой болчихож байгаа юм.

Тэгэхээр үүнтэй уялдуулаад бид нар нэн яаралтай бид энэ угаах үйлдвэр түрүүнд Батжаргал гишүүний тэр ярьсан энэ чанарын асуудал яригдаад байгаа учраас бүх юмны гаргалгаа угаах үйлдвэр. Үүнийг яаралтай ашиглалтад оруулах, үүнийг зорьж ажиллаж байгаа юм гэдгийг тодотгож хэлье.

Т.Энхтүвшин: Өнөрболор гишүүн.

Ч.Өнөрболор: Нүүрс тойрсон асуудал үнэхээр олон нийтэд өндөр хүлээлттэй байгаа асуудал. Эрдэнэс Таван толгой компанийн мэдээллийг сонслоо. Өмнө нь энэ Засгийн газраас өгсөн мэдээллээр харвал өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол Улс 45.2 их наяд төгрөгийн нүүрс борлуулж, үүнээс улсын төсөвт бол 10 их наядыг төвлөрүүлсэн байдаг юм байна билээ. Тэгээд энэ компанийн хувьд энэ 2010 оноос өнгөрсөн 11 сар хүртэл Бэт томилогдох хүртэлх хугацаанд 86 сая тонн нүүрсний 12.7 их наяд төгрөгийн борлуулалтыг хийгээд, 3 их наяд төгрөгийн татвар төвлөрүүлсэн гэдэг тайлан байгаа. Тэгэхлээр энэ компаниас 10 жил олсон орлогын 50 хувийг та нар 5-хан сарын хугацаанд биелүүлсэн байна гэж энэ тайлангаар ингээд харагдаж байна. Нэг талаасаа бол үнэхээр сайн ажилласан байна.

Гэхдээ БЭТ энэ яг нөхцөл байдал дээр энэ компанийнхаа талаар ер нь дүгнэлт хийсэн үү. Жинхэнэ ер нь энэ далд эдийн засаг чинь энд байгаад байгаа юм биш үү. Тэгэхлээр энэ дээр ер нь ямар дүгнэлт хийсэн юм бэ. Би Ганбат даргаас үүнийг албан ёсоор байр суурийг нь асуумаар байна. Энэ тайлан дээрээс харахад, 27 дугаар хуудас дээр, энэ компани сүүлийн жилүүдэд бол ашигтай ажиллаж байгаа. Иргэдээс хамгийн их хүлээлтэд байгаа, ер нь энэ хүсэлт дунд бол энэ ноогдол ашгийг хуваарилах асуудлыг бол маш их асууж байгаа. Энэ тал дээр бас албан ёсоор хариулт авмаар байна. 1072 ширхэг хувьцааны асуудлыг бол бас гишүүд нэлээн их хөндөж ярьж байна. Ер нь даруй даруй 10 жил өнгөрсөн байна. Энэ 10 жилийн өмнө 1072 ширхэг хувьцааг иргэн бүрд 1 сая төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний үнэлгээтэй байсан. Тэгэхээр одоогийн энэ 2.2 сая иргэн иргэнд хуваарилсан байж байгаа хувьцааны өнөөгийн үнэ цэн ер нь яг хэд байгаа вэ гэдэг дээр бас нэг ойлголт өгөх нь бас зүйтэй байна гэж бодож байна.

Ер нь энэ нүүрс энэ дэлхийн эдийн засагт бас нэлээн шахагдаад ирсэн, ийм цаг ойртож байна. Хятад ардын улсын хувьд ч гэсэн 2025 оноос хойш 5 жилийн дотор энэ нүүрсний хэрэглээг хязгаарлах амлалттай яваа. Гэтэл манай уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх нэмүү өртөг шингээсэн энэ бүтээгдэхүүнийг бий болгох, энэ үйлдвэрлэлийг бий болгох энэ зорилгоор 4.9 тэрбум төсөвт өртөгтэй төсөл хөтөлбөр хийж хэрэгжүүлэхээр зорьж байгаа юм байна. Үүнээс 1.5 тэрбумын санхүүжилтийг нь шийдвэрлэхэд байгаа юм байна. Тэгээд ер нь 2026 он хүртэл гэж ойлголоо. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор энэ нөхцөл байдлыг ер нь яаж уяж энэ компанийн цаашидын стратеги бодлогыг ер нь юу гэж тодорхойлж байгаа вэ? Энэ

менежментийг ер нь хэрхэн зохион байгуулахаар ер нь авч үзэж байгаа вэ?

Засгийн газрын энэ үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 3.2.1.6-д, сая Ганбат дарга ч гэсэн нэлээдгүй их онцлон тэмдэглэж байна. Энэ нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах асуудал маш чухал гэж байна. Гэтэл энэ яг ажил нь бол 30 хувьтай байгаад байгаа юм байна. 2024 оны 7 сард ашиглалтад оруулахаар энд тайланд байна. Тэгэхлээр ийм гүйцэтгэлтэй байгаа бүтээн байгуулалт чинь яг 2024 оны 7 сард амжиж ашиглалтад орох уу? Яг бүрэн ашиглалтад орох уу?

Дараагийн нэг асуудал нь бол, энэ оптик гэрээний тоог та бүгд цөөлжээ. 178 энэ борлуулалтын гэрээнээс 101 борлуулалтын гэрээ болгож цөөлсөн байна. Ер нь энэ 101 энэ гэрээ дотор нууц гэрээ гэж ер нь байгаа юу. Улсын Их Хурал ер нь мэдэхгүй байгаа, яг энэ компанийн яг үндсэн зорилго зорилтод нийцэхгүй, энэ төсөл санхүүжүүлэх өөр гэрээ нь.

Т.Энхтүвшин: Өнөрболор гишүүнд нэмээд 1 минут өгөөрэй.

Ч.Өнөрболор: Тэгэхлээр дахиад давтаад хэлчихье. Улсын Их Хурал ер нь мэдэхгүй яг энэ компанийн үндсэн зорилго зорилтод нийцэхгүй өөр төсөл санхүүжүүлэхээр гэрээнүүд байдаг юм уу? энэ тайлан дээрээс ингээд харахаар энэ дээр 1 төслийг дурдсан байх шиг байсан. Газрын тос дамжуулах хоолой гээд. Энэ бол 8.5 хувьтай байгаа юм байна. Тэгээд энэ 4.9 тэрбум ам.долларын төсөвт өртөгт орчихсон байгаа юм байна гэж ойлгож байна.

Дараагийнх нь нэг асуудал. Энэ танилцуулгаас харахад энэ Богд хаант төмөр замыг зогсоосон гээд ингээд тэмдэглэчихсэн байгаад байна. Гэтэл

амьдрал дээр бол 41 сая долларыг санхүүжүүлчихсэн байна гэж харагдаж байна. Тэгэхлээр энэ талаар цаашидаа энэ санхүүжилт хийсэн асуудлаа ер нь яаж зохицуулах гэж авч үзэж байгаа вэ? Ер нь голдуу энэ.

Т.Энхтүвшин: Ганбат дарга хариулах уу? Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Ерөнхийдөө энэ нүүрс тойрсон нүүрсний ялангуяа борлуулалт тойрсон энэ далд хэлбэртэй байсан асуудлыг шийдвэрлэх хамгийн зөв арга энэ биржийн асуудал байгаа юм. Өмнө нь 2011 онд Эрдэнэс Таван толгой компани анхны борлуулалтаа хийж нүүрсээ зарж эхэлсэн байдаг. Ингээд хэн ямар үнээр авч байгаа нь тодорхой бус байдаг байсан. Одоо бид үүнийг цаашидаа ер нь энэ онд бид нар 30 хувиа биржээр арилжаалах ийм зорилт тавьж, цаашидаа бүх нүүрсээ биржээр арилжаад эхлэхээр энэ нүүрс тойрсон далд хэлбэрийн юмнууд бүгд алга болно. Нөгөө талдаа борлуулалтаа ил тод нээлттэй болгочихно. Хамгийн зөв засаглал, хамгийн зөв менежмент энэ биржээ гэж бид ингэж харж байгаа.

Дараагийн асуудал нь, бид биржээр борлуулалт тавиад ирэхээр нэмүү өртөг шингээсэн, яаж энэ нүүрсийг бид үнэ хүргэж ингэж арилжаалах вэ, яаж эцсийн хэрэглэгчид хамгийн үнэтэй зарах вэ гэхээр, нүүрс баяжуулах буюу энэ угаах үйлдвэрийг ашиглалтад оруулах. Одоо гэрээгээрээ 2024 оны 7 сард орох ийм гэрээтэй. Бид үүнийг гүйцэтгэгч компани нь Норинко интернэйшнл гэж компани гүйцэтгэгчээр ажиллаж байгаа. Энэ гэрээн дээр зарим гүйцэтгэлээ нүүрсээр авах, заримыг нь мөнгөөр авах гэдэг ийм гэрээтэй байгаа. Бид энэ дээр эхний ээлжид ер нь энэ нүүрсээр төлбөрөө төлдөг юмнуудыг бүгдийг нь зогсоосон.

Тэгэхдээ эд нар бид ханшийн эрсдэл үүрээд байгаа учраас энэ нүүрсээр төлбөр төлөх асуудлууд дээр бас эргэж анхаарч үзээч гэдэг ийм асуудлыг энэ нүүрс угаах үйлдвэр гүйцэтгэгч компанийн зүгээс тавьж байгаа юм. Бид ямар нэгэн төлбөрийг саатуулж байгаа юм байхгүй. Үүнийг хугацааны хувьд бид санхүүжилтийн бүрэн өгч байна. Та нар гэрээгээр үлдсэн хугацаагаа биелүүлээч гэдэг ийм шаардлага тавиад ажиллаж байгаа. Бүр 2024 оны 7 сараас өмнө оруулбал бүр сайн байна гэдэг ийм байдлаар бид ажиллаж байгаа. Тэгэхээр энэ угаах үйлдвэрийг ашиглалтад оруулснаараа бид илүү нэмэлт орлого олно гэдэг ийм байдлаар зорьж ажиллаж байгаа. Нөгөө талдаа бид бас өртөг зардлыг бууруулах ийм байдлаар түрүүн тэр конверын систем гэдэг юмнуудыг ярьж байгаа.

Нөгөө талдаа бид өнгөрсөн 2022 оны 12 сарын 8-ны өдөр Засгийн газрын шийдвэрээр бүх гэрээнүүдийг ил тод нээлттэй болгосон. Энэ мэдээллүүдийг 2022 оны 11 сарын 8-ны өдөр бүх худалдан авагчтай гэрээ, бүх энэ Эрдэнэс Таван толгойн гэрээгээр ажил гүйцэтгэгч компаниудын бүх мэдээллүүдийг ил тод нээлттэй тавьсан. Гэхдээ худалдан авагч нарын зүгээс бас та нар 2 тал харилцан тохиролцсон гэрээний бүх мэдээллийг ил тод тавилаа гэдэг асуудлыг босгож тавьсан. Бид үндсэн нөхцөлүүдийг нь бүгдийг нь тавьсан. Эрдэнэс Таван толгой компани дээр ямар нэгэн байдлаар 12 сарын 8-ны өдрөөс хойшоо нууц гэсэн ийм гэрээний юмнууд байхгүй байгаа. Бид бүгдийг нь ил тод нээлттэй мэдээлээд ингээд явчихсан байгаа.

Оптик гэрээнүүд гээд энэ голдуу төмөр замын төсөл дээр Гашиунсухайт төмөр зам, Богд хаант төмөр зам дээр энэ оптик гэрээнүүдийн асуудлууд байгаа. Энэ гэрээнүүдийн хугацаа дууссан, нүүрсээр төлбөр төлөх

гэрээнүүдийн хугацаа дууссаныг нь бид нар дуусгавар болгочихсон. Дахиж тэн дээр сунгах энэ асуудлыг нь тавиагүй. Хугацаа нь болоогүй Гашуунсухайт төмөр замтай холбоотой 1 гэрээний асуудал байгаа. Тэр гэрээнийх нь дагуу энэ төмөр замын асуудлуудаа дуусгавал бүрэн бололцоотой юм уу гэдэг ийм байдлаар юмнууд явж байгаа. Богд хаант төмөр зам дээр 10 сарын 26-нд онцгой дэглэм тогтооход Таван толгой төмөр замын дансанд өгчихсөн байсан 115 тэрбум төгрөг байгаа. Түүнийг бид нар буцааж татаж авсан. Нөгөө талдаа нүүрсээр зарим төлбөрүүд ингэчихсэн, Зам, тээврийн яамнаас энэ Богд хаант төмөр замын асуудлыг цаашид ярих талаар яагаад, энэ тал дээр тооцоогүй. Богд хаант төмөр зам, Гашуунсухайт төмөр замыг ерөөсөө л ганцхан компани гүйцэтгэж байгаа шүү дээ. Бодь интершнл.

Т.Энхтүвшин: Ганбат даргад 1 минут нэмээд өгье.

Ж.Ганбат: Тэгэхээр энэ Богд хаант төмөр замын гүйцэтгэгч компанитай яриад ер нь энэ өр төлбөрийн асуудлуудаа тооцоо нийлээд нэг талд нь гараад ингээд яв гэдэг асуудлууд ярьж байгаа. Богд хаант төмөр зам дээр Бодь интершнл компанийн зүгээс тэр хийчихсэн гэрээнүүдийн асуудлыг Гашуунсухайт төмөр зам руу шилжүүлж өгөөч гэдэг ийм хүсэлтийг удаа дараа тавьж байгаа. Үүнийг нэгтгээд бид нэг компанид гүйцэтгэгч учраас явъя гэдэг ийм байдлаар. Бид бол Гашуун Сухайт төмөр замын асуудлыг яаралтай холбох энэ ажлуудыг, дутуу ажлуудыг гүйцээх энэ чиглэлд нь бид нарын хувьд ач холбогдолтой байж, энэ дээрээ анхаараач гэдэг ийм байдлаар Бодь интершнл компанийг шахаж ингэж ажиллаж байгаа.

Нөгөө талдаа, 1072 хувьцаа эзэмшигч нарт 2019 онд 1 удаа 1 иргэнд 96000 төгрөгийн ноогдол ашиг өгсөн байдаг юм байна билээ. Тэгээд дараа нь 2020, 21 гээд тэгээд ковидтой нөлөөл.

Т.Энхтүвшин: Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Эрдэнэс Таван толгой компани БЭТ томилогдсоноос хойших санхүүгийн тайлангаа зөвлөлдөөд явж байна. Нэлээн тийм өөдрөг сайн гэхээр. Тэгэхээр энд би бас онцолж хэлж байгаа нь нөгөө нүүрсийг сорчилж олборлодог шиг тэнд голдуу тийм сайн мэдээгээ их онцлоод хэлээд байна уу гэж. Үүний цаана энэ үйл ажиллагааны тайланг ярихын тулд заавал нэг баланс гэдэг юм ярьдаг. Баланс дээр чинь өр төлбөр болоод олон зүйлүүд байдаг. Тэгэхээр ерөөсөө тэр өр төлбөртэй болоод асуудлыг харьцуулж харах үзүүлэлтүүд нь ерөөсөө энэ тайлан дотор чинь байхгүй юм. Эрдэнэс Таван толгой компани өнөөдөр яг урт болоод богино хугацаанд ямар өртэй байгаа юм. Өрчилж олсон орлого гэдэг нэг зүйл байдаг. Өртэй дүйцэхүйц. Тэр тоо өнөөдөр яг хэд байгаа юм. Энэ тухай нэг мэдээлэл өгөөч.

Тэгэхээр энэ нь бүгдтэй холбоотой яригдах нэг зүйл чинь заавал энэ компанийн үр ашиг, зохист харьцааны тухай зүйлүүд гарч ирнэ. Үүний цаана тэр нэг үндсэн үйл ажиллагааны бас баахан Таван толгой түлш гэдэг компани нь бараг 1 их наяд шахам төгрөгийн татаас ч юм уу, дэмжлэг ч юм уу ингээд өгчихсөн. Энэ чинь дахиад нөгөө өөр уурхайнуудад дэмжлэг өгсөн ч гэнэ үү. Энэ бүгд чинь нөгөө хувьцаа эзэмшигчдээсээ үүнийгээ асуудаг юм уу, асуудаггүй юм уу. Зүгээр дураараа ингээд үйл ажиллагааны бусад зардлуудыг бид нар энэ яг ямар дүрэм журмаараа гардаг юм. Хувьцаат компани гэж байгаа. Тэгээд дураараа

үйл ажиллагааны бусад зардлууд гээд их наядаар нь ингээд цаана нь гараад явчихсан байдаг. Энэ өөрөө яг шийдвэрүүд нь яаж гардаг юм. Тэгээд ядаж дунд хугацаандаа энэ олон улсын нэг санхүүгийн арга хэрэгслүүд байдаг. Энэ урьдчилж орлого олох, наад нүүрсний үнэ чинь сүүлийн хагас жилээр бодвол сар бүхэн унаж байгаа. Тэгэхлээр урьдчилж олох орлого, ирээдүйд зарах энэ санхүүгийн арга механизмуудыг бид нар энд ашиглах, үүнийг яаравчлахгүй бол. Энэ дээр ямар бодлогууд байдаг юм.

Яг үнэндээ олон нийтэд хэлэхдээ ам нөхцөлөөр биш хил нөхцөлөөр зарахаар их орлого олж байна гээд байх юм. Тэр хооронд чинь зарлага гардгаараа л гарч байгаа шүү дээ. Энэ чинь зүгээр л аль нөхцөлөөр гэрээ хийх вэ гэдэг санхүүгийн нэг арга механизмууд шүү дээ. Худалдааны энкотермос гэдэг Дэлхийн худалдааны байгууллагаас зөвшөөрсөн нөхцөлүүдийг нэгийг нь нөгөөдхөөр нь хийчхээд, бараг нэг нь хууль бус юм шиг, нөгөөдөх нь хууль ёсны дагуу юм шиг. Энэ чинь зүгээр л цаана нь санхүүгийн арга механизмууд үүний цаана явж байгаа шүү дээ. Дахиад үүний цаана Эрдэнэс Таван толгой компани тээврээ өөрөө хийхээр их ашигтай ч юм шиг. Энэ бол зүгээр нэг бизнесийн төрөлжилтийн бараг эсрэг зүйлүүд яваад байх юм. Энэ бүхэн дээрээ бас үнэн бодит байдлыг хэлээд ямар хугацаанд эргэж хэвийн бизнесийнхээ горим дүрэм рүү орох юм. Олон улсын дэг журам руугаа орох юм. Энэ дээр бас нэг тодорхой хэмжээний ийм тайлан мэдээн дээрээ ч гэсэн, та нар бас хэлж ярьж байгаа үгээ бодохгүй зүгээр ингээд бусад нь хууль бус юм шиг ийм зүйлүүд ам нөхцөлөөр зарахаар хууль ёс юм шиг, урьдчилж зарахаар хууль бус юм шиг. Энэ бүгдийг хууль ёсны дагуу болж байгаа юм шиг нэг ийм нөхцөл байдлууд бас энд яригдаад байх юм. Тэгэхээр энэ бүгд дээр ирээдүйн биш юм гэхэд ядаж дунд хугацааны тайлбарууд хэлээч.

Тэгээд тэр баланс дээр байгаа хамгийн гол нь урт болон богино хугацаат өрүүд, урьдчилж олсон орлого гэдэг тоонууд ер нь динамик нь өөрөө яг ямар байгаа юм. Энэ дээр яг тодорхой тоонууд хэлээч.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон, Ганбат дарга.

Ж.Ганбат: Энэ слайд дээр энэ 14 дэх хуудсан дээр байгаа. Өмнө нь онцгой дэглэм тогтоох үеийн нөхцөл байдал ямархуу байсан бэ гэдэг ийм мэдээллүүдийг өмнө нь ийм байсан. Одоо үүнийг төлж барагдуулсан нь 14 дэх слайд дээр би харуулсан юм. Ер нь Эрдэнэс Таван толгой компанийн яг 12, 13 жилийн түүхэнд дандаа мөнгийг нь урьдчилж авч байсан юм. Эхлээд мөнгийг нь авчихдаг, дараа нь түүндээ нүүрсээ ачуулдаг. Бүүр 2010, 11 оноос хийгдчихсэн Чалко гэж компанитай байгуулчихсан гэрээ байгаа. Одоо энэ 2027 онд дуусгавар болохоор гэдэг ийм нөхцөлөөр. Бид 2022 оны хавар 2 сар, 3 сард нийтдээ урьдчилж 603 сая ам.доллар авсан юм байна билээ. Үүнээс яг 10 сарын 26-нд онцгой дэглэм тогтоох үед 582 сая ам.долларын урьдчилж орсон орлого бүртгэлтэй байсан. Үүнийг бид нар нүүрснийх нь урьдчилсан орлогоор нь нүүрсийг нь өгөх энэ асуудалтай тулгарсан. Нийт зарж байгаа нүүрсний 19 орчим хувь нь эндээ тооцогдоод, бас бүрэн орлого нь орж ирэхгүйгээс болоод валютын орох урсгал сөрөг байсан. Үүнийг бид энэ оны 3 сарын 31-ний байдлаар 286.4 сая ам.долларт хүргээд бууруулсан. Үүнийг уг нь 1, 2, 3 сар, 4 сарын 1-нд бууруулах гээд зорьсон. Гэхдээ энэ дээр Чалко гэж компанитай холбоотой асуудлаар үүнийг бууруулж чадаагүй. Чалко гэж компани 1 дүгээр улирлын нөгөө “С” зөвшөөрөл гэдэг юмыг авахдаа өөрсдөөсөө хамааралтайгаар тэр зөвшөөрлөө авч чадаагүй. Бид түүнийг

олгоогүй. Үүнтэй холбоотой Чалко компани 1 дүгээр улиралд ямар нэгэн байдлаар нүүрсээ авч чадаагүй. Нөхцөл байдлаас болоод урьдчилж орсон орлогыг 582 сая байсныг бууруулаад яг 4 сарын 1-ний байдлаар 286.4 сая ам.долларын үлдэгдэлтэй байна. Үүнийг бид аль болох богино хугацаанд дуусгаж байж, бид нүүрсийг зарсан бол тэр мөнгө нь бүрэн орж ирдэг ийм системээр шилжих ёстой.

Үүнтэй холбогдуулаад онцгой дэглэм тогтоосон 10 сарын 26-наас хойшоо Эрдэнэс Таван толгой компани урьдчилж орлого олохгүйн төлөө ажиллаж байгаа. Бид яг бизнесийн зарчмаар нүүрсээ зарлаа, мөнгө нь орж ирдэг, үүгээрээ борлуулалтаа тооцдог, ямар нэгэн байдлаар урьдчилж мөнгө авч өрийн дарамтад орохгүй гэдэг ийм байдлаар богино, дунд хугацаандаа ер нь цаашидаа ийм бодлого барьж явах нь зөв гэдэг байдлаар мөнгөн хөрөнгийнхөө урсгал, санхүүгийн бүх үзүүлэлтүүдийг бид тооцож явсан. Энэ хүрээндээ урт хугацаат өр төлбөр онцгой дэглэм тогтооод 450 сая ам.доллар байсан. Бид мөнгөн хөрөнгийнхөө урсгалыг зөв тооцоод, борлуулалтаа зөв тооцоод өмнө гаргачихсан байсан Эрдэнэс Таван толгойн бонд гэдэг энэ төлбөрөөс сая 2023 оны 4 сарын 7-ны өдөр бид нар 236.5 тэрбум төгрөг, 39 сая ам.долларыг энэ төлж, өнгөрсөн 7 хоногт барагдуулсан байгаа. Дараагийн 2 дахь ээлжийн төлбөр энэ оны 8 сард төлж барагдуулна. Үүнийг би бид дахин санхүүжилт гэдэг байдлаар хандаагүй. Бид яг өөрсдийнхөө орлогоосоо мөнгөн хөрөнгийнхөө удирдлагын хүрээнд өөрөөр нь тооцож ингэж өр төлбөрийг барагдуулсан байгаа.

Нөгөө талдаа 2022 оныхоо төсвийг 1.7 их наядын ингээд алдагдалтай өөрөөр хэлбэл баталчихсан. Энэ хүрээндээ баахан өөрийнхөө ачааллаас ихэссэн

төслүүдийг санхүүжүүлдэг бас ийм асуудал байсан. Үүнийг нь бид жилийн эцсийн байдлаар 385 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэйгээр бид гаргасан, дансандаа. 385 тэрбум дансны үлдэгдэл дээр гаргасан. Нөгөө талдаа бид 123 тэрбум төгрөгийн гэрээт олборлогчдын өр төлбөрийг барагдуулсан. Энэ 2021 оны 8 сараас хойш.

Т.Энхтүвшин: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Би их тодорхой асуулт асуусан. Өнөөдөр 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар Эрдэнэс Таван толгой компани ямар өртэй байна вэ. Урт болон богино хугацаат дүн урьдчилж олсон орлого. Энэ 3 дүнгээ хэлчхээч ээ. Сая баахан юм яриад дунд нь зүгээр л төөрөгдөөд явчихлаа. Дахиад дээрээс нь сая түрүүн таны үгэнд гарч байгаагаар энэ чинь ямар улсын төсөв биш дээ. Компани өөрөө алдагдалтай, ирээдүйн төсөв батална, тэр нь 1.7 их наядын алдагдалтайгаар баталчихсан ч гэнэ үү. Энэ дээр нэмээд дахиад нэг тийм асуудал цаана нь явж байгаа юм байна. Өртэй мөртөө. Тэгээд баахан элдэв янзын үндсэн үйл ажиллагааны биш ажил хийгээд байдаг. Түүнийгээ хувьцаа эзэмшигчдээсээ асуудаггүй. Тэгчхээд дахиад энэ ашигтай гэж байгаа компанид цаана нь 1.7 их наядын өр нэмж 2023 онд тавина гэж төсөвлөсөн юм шиг байна шүү дээ. Эдгээр тоонуудаа дахиад нэг тодруулж өгөөч. Тодорхой тоонууд хэлээд өгөөч.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Ж.Ганбат: Яг энэ 2023 оны 4 сарын 1-ний байдлаар Эрдэнэс Таван толгой компани дээр урт хугацаат өр төлбөр 1.1 их наяд төгрөг дахиад байна. Бид үүнийг бас төлөх ёстой. Үүнээс урт хугацаат өр төлбөр дотроо бид бондын

өр төлбөр дахиад 383.5 тэрбум төгрөгийн өр байна. Тэгэхээр энэ өр төлбөрүүдийг бид энэ сая 5 сарын хугацаанд барагдуулж ингэж ажилласан байгаа. Би тэр 1.7 их наяд төгрөгийн алдагдалтай, тэгээд энэ 1.7 их наяр мөнгөн хөрөнгийн дутагдалтай төсөв баталчихсан. Хаанаас авах нь тодорхойгүй. Харин яг зөв. Үүнийг тэр нөгөө урьдчилж мөнгийг нь авах, нүүрсээ урьдчилж борлуулах замаар олно эсвэл өр зээл тавина гэдэг байдлаар мөнгөн хөрөнгийн хувьд 2022 оны төсвийг алдагдалтай баталсан байсныг оны сүүлээр.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 3 дугаар номерын микрофоныг нэмээд өгөөрэй.

Ж.Ганбат: 1.1. Тэр 4.9 тэрбум төгрөг бид нар нөгөө төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж байгаа шүү дээ. Түүнээсээ 1.5 тэрбумын санхүүжилтийг нь өгчихсөн ийм байгаа.

Т.Энхтүвшин: Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эрдэнэс Таван толгой компани дээр бүрэн эрхт төлөөлөгч томилогдсоноос хойш тодорхой үр дүн гарсан тухай мэдээллүүдтэй танилцлаа. Бас боломжийн, боломжийн үр дүнгүүд гарсан байна гэж харж байна. Тэгэхээр энэ чиглэлээр 3 асуулт танаас асууя. Өнөөдөр бид бүхэн нүүрснийхээ үнийг хилийн нөхцөлөөр борлуулж байна. Даруй уурхайн аман дээрээс борлуулж байснаас 70 наяд доллароор нэмэгдүүлж чадлаа гэж та тайландаа тусгасан байна. Яг өнөөдөр олон улсын зах зээлд нүүрсний үнэ коксожсон, сул коксожсон хэлбэрээсээ шалтгаалаад 213-аас 267 америк доллар байгаа. Тэгэхээр бид нар энэ түвшинд хүрэхийн тулд цаашидаа хэрхэн ажиллах ёстой вэ гэдгээ бодох ёстой гэж харж байна. Яг энэ түвшинд

олон улсын зах зээл дээр байгаа үнээр бид нар борлуулах боломж байгаа юу нэгд.

Борлуулах боломж байгаа бол борлуулахын тулд бид нар ямар хэмжээний технологийн шийдлүүдийг, хөрөнгө оруулалтуудыг хийх ёстой юм бэ. Энэ тал дээр судалж гаргасан тодорхой төлөвлөгөө байгаа юу гэдэг дээр хариулт авъя.

Хоёрдугаарт нь, компани олборлолтынхоо түвшинд Монгол Улсад татвар төлж байгаа юу. Хуучин олборлолтынхоо түвшинд татвар төлдөг. Доод зэргийн нүүрснүүдээ бид нар ямар нэгэн байдлаар борлуулж чаддаггүй, сорчилж олборлож борлуулдаг гэдэг асуудал гардаг. Тэгэхээр сая таны тайланд бид нар аль болох сорчлохгүйг хичээж байгаа гэж байгаа. Тэгэхээр бүхий л төрлийнхөө нүүрсийг борлуулах боломжтой гэж үзэж байна гэж би ойлгогчихлоо. Тэгэхээр тийм боломжууд гарч ирж байгаа юм уу. Тийм боломж гарч ирж байгаа бол хэрхэн зохион байгуулалтад оруулж байгаа юм бэ. Ингэснээрээ ашигт үйл ажиллагаа чинь хэрхэн нэмэгдэх юм. Доод зэргийн нүүрсээ бид борлуулж чадаж байгаа юм уу, яг үнэндээ. Борлуулбал яаж ямар үнэ өртгөөр гэдэг дээр нэг хариулт өгөөч ээ.

Гуравдугаарт нь, зарим нэг гишүүд бас ярилаа. Ноогдол ашигтай холбоотой асуудлыг. Яг үндсэндээ энэ компани ноогдол ашиг гэдэг зүйлээ иргэддээ олгохгүйгээр, өөрсдөө хөрөнгө оруулалт хийх ажлуудаа дур мэдэн ярилцахгүйгээр шийдэж байгаа зүйлүүд бий. Дур мэдэн гэдэг нь хаашаа ч юм бэ дээ бас. Ер нь хувьцаа эзэмшигчидтэйгээ ярилцахгүйгээр энэ шийдлүүд гарч байгаа. Таван толгойн төмөр зам ч гэдэг юм уу, бусад олон төсөл хөтөлбөрүүд дээр хөрөнгө оруулалт хийгээд ингээд яваад байгаа

юм. Тэгэхээр энэ цаашлаад юу гэж иргэд харж байгаа вэ гэхээр Монгол Улсын Засгийн газар ийм шийдэл гаргаж байна л гэж харж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын Засгийн газар өөрөө хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг зөрчөөд, дээрээс нь хуулиа биелүүлэхгүй ийм шийдэл гаргаж болох юм уу. Би ойлгож байгаа. Мэдээж саяын дэлхийн олон улсын зах зээл дээр байгаа үнэд хүрч нүүрсээ борлуулахын төлөө тодорхой технологийн шийдлүүд гаргах, хөрөнгө оруулалтуудыг хийх ажлууд байгаа. Нэн чухал зүйл гэж ойлгож байгаа. Тэгэхдээ бид нар цагаан дээр хараар биччихсэн хуулиа биелүүлж, энэ хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хангаж ажиллах нь бас нэг талдаа үүрэг гэж харж байгаа юм. Тэгэхээр аль, алийг нь хийх ёстой зүйл юм аа.

Тэгэхээр энэ дээр бүрэн эрхт төлөөлөгч дахин надад тодруулга хэлж өгөөч ээ. Үйлдвэр барина шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлнэ гэдэг чинь.

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг 3 номерын микрофон.

Ж.Ганбат: Батлут гишүүний асуултад хариулъя. Ер нь бид сая бирж дээр 7 удаагийн арилжаа хийсэн. Эрдэнэс Таван толгой компани яг өнөөдрийн байдлаар түүхий нүүрсийг борлуулж байгаа юм. Бид цаана ганц мод боомт дээр 198 хавьцаа үнэ байхад бид 178.6-аас дуудсан. Тэгээд 179, 180 гаргаж зарж үзсэн. Энэ ганц мод нөхцөлтэйгөөр. Эрдэнэс Таван толгой компани яаж нүүрсээ үнэ хүргэх вэ гэх дээр яг л нөгөө түрүүний ярьдаг угаана. Боловсруулалт хийгдэнэ. Ингэж байж л бид цаашаага зарна. Нөгөө талдаа энэ дээр бас биржийн нөхцөлүүдээ, одоо бол бид ганцхан нөхцөлөөр бирж дээр дуудаж байгаа шүү дээ. Бид олон гарцуудаар дуудна. Бид Эрээн нөхцөлөөр дуудаж бас үзэх гээд Эрээн Замын-

Үүдийн бас төмөр замын ачаалал дээр бас боломж олдохгүй байгаа. Тэгэхээр бид ер нь төмөр замыг аль болох энэ Хангийн төмөр замыг яаралтай холбох ёстой. Гацуунсухайт төмөр замыг яаралтай холбох ёстой. Тэгж байж бид цаашаага эцсийн хэрэглэгчид хүргэх ийм бодлого явах ёстой юм байна билээ ер нь. Мэдэхгүй. Яг одоо автомашинаар тээвэрлээд ганц мод нөхцөлтэй тэр Баяннуур гэдэг аймгаар дамжиж зайлшгүй зарагддаг. Түүний бас хүндрэлтэй асуудлууд байна. Ийм учраас бид энэ олон гарцуудаар, нөхцөлтэйгөөр бид нар биржийн арилжаагаа явуулаад, угаагаад арилжих юм цаашаа улам илүү үнэ хүрэх, 60-80 долларын үнэ хүргэж зарна боломж байна гэж байгаа юм.

Нөгөө талдаа яг энэ компани 13 жилийн түүхтэй компани. Сорчилж ирсэн. Угаасаа манай нүүрс юу нь хамгийн сайн зарагддаг вэ гэх дээр, тэр хатуу сайн чанарын коксжих нүүрс зарагддаг. Тэгэхдээ түүнийг сорчлоод ирчихсэн учраас энэ компани дээр яг үлдсэн энэ нөөцийг нь ингээд үзэх дээр хатуу коксжих нүүрс 31 хувь нь, сул коксжсон буюу хагас коксжих нүүрс нь 21 хувь байна. Эрчим хүчний нүүрс 48 хувь байна. Тэгэх дээр бид энэ хатуу коксжих нүүрсийг сорчилж зараад, зараад ямар хэмжээтэй орлого олох вэ гэдэг нь эргээд асуудал үүсчихсэн. Энэ компанийн цаашдын хувь заяа энэ ордын нөөц яах вэ гэдэг. Тэгэхийн тулд бид угаах үйлдвэрийг ашиглалтад орно. Нүүрсүүдийг бас холих ингэж чанарын хувьд дээшлүүлэх ийм юм байгаа. Нөгөө талдаа эрчим хүчний нүүрсийг бид 2 удаа сая арилжаад, 200 орчим мянган тонныг арилжиж чадсан. Би зүгээр туршилтаар туршиж үзсэн юм. Тэгэх дээр эндээсээ ямар дүгнэлт хийсэн юм гэхээр бас манай урд хөршид манай эрчим хүчний нүүрс зарагдах бас боломж байна уу гээд. Дахиад бид энэ 7 хоногийн 5 дахь өдөр энэ хагас коксжих

нүүрсийг бас арилжиж үзэх гэж байх юм. Энэ талаар энэ компани 12, 13 жилийн түүхэнд хагас энэ хагас коксжих нүүрсийг 212 мянгыг л зарж үзэж байсан юм байна билээ. Өөр зарж байгаагүй.

Тэгэх дээр энэ эрчим хүчний нүүрс болон хагас коксжих нүүрсийг бид ямар нэгэн байдлаар зарж байж бид цаашаа амжилттай явна. Зарж чадахгүй нөгөө сорчлох гэдэг юм руу дахиад орно. Сорчлохоос гадна сорчлоод, сорчлоод бид цаашаа явж чадахаа больж байна. Нөгөө талдаа уулын ажлын нөхцөлөөр далд уурхай гэдэг юм бид нар хийхээс өөр аргагүй. Тэгэхгүй бид энэ сайн чанарын 31 хувийн нүүрсээ авахад бас хүндрэлтэй нөхцөл байдал руу орчихсон. Яг уулын нөхцөл байдал нь ийм юм байна билээ бодитойгоор. Тэгэхээр бид зах зээл дээрээ энэ сул коксжсон нүүрс гэдгийг таниулах, энэ талын зах зээлээ судлаад тэгээд бирж дээр бид бас туршилтаар арилжиж үзээд, энэ амжилттай бол бас том амжилт түүхэндээ ингээд. Эрчим хүчний нүүрс дээр 2 удаагийн арилжаа амжилттай болоод ингээд зарчихсан ийм байгаа юм.

Нөгөө талдаа компани өмнө явж ирсэн түүхүүд юмнуудыг үзэхэд, гүйцэтгэх удирдлагын зүгээс, компанийн зүгээс жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргаад ТУЗ-дөө асуудлаа танилцуулдаг. Тэгээд ТУЗ ноогдол ашиг тараах эсэхийг нь шийддэг. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдээ буюу Засгийн газарт асуудлаа танилцуулдаг ийм байдлаар явж ирсэн байгаа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Тийм, харин тийм. Бид яг өмнө нь олборлолтын түвшинд сая 12, 13 жилийн түүхэнд жишээ нь сул коксожсон нүүрсийг дан овоолго үүсээд, тэнд татвар төлж байгаа юм байхгүй.

Тэгэхээр бид эрчим хүчний нүүрс сул коксожсон гээд ерөөсөө эндээс гарч байгаа бүх бүтээгдэхүүнээ зарахаас өөр аргагүй ийм зам руу орж байгаа гэдэг нь саяын миний хэлж байгаа энэ хатуу коксожсон нүүрс 31 хувь, хагас коксожсон 21 хувь, эрчим хүчний нүүрс 48 хувийг нь эзэлж байна. Тэгэхээр бид дандаа сорчилж нөгөө сайн чанарын нүүрсээ борлуулж ирсэн. Одоо бид цаашидаа энэ нөхцөлд, уулын нөхцөл байдлынхаа хувьд ч хүндрэлтэй байдал руу орчихсон. Бас дахиад бид цаашаагаа сорчлоод яваад байх ийм боломжгүй байгаа учир өмнө нь дандаа хатуу сайн чанарын нүүрсээ зарж тэндээсээ татвараа төлж ирсэн. Бусад дээр нь овоолго байдлаар үүсгээд яваад ирсэн. Үүнээсээ л аль болох зайлсхийж гаргаж байгаа бүх бүтээгдэхүүнээ зардаг, үүнээсээ татвараа бүрэн төлдөг больё гэдгийг ийм зорилт тавьж байгаа юм. Тэгээд зах зээлээ ч бас энэ рүү судалж байгаа.

Т.Энхтүвшин: Батлут гишүүн.

Д.Батлут: Тодорхой хэмжээнд сайн ажилласан гэдгийг онцолсон байгаа. Тэгэхээр цаашидаа ер нь бүх төрлийнхөө нүүрснийг сорчлохгүйгээр ашиглах тал дээр технологийн шийдлүүдийг гаргаж ажиллах нь их зүйтэй юм. Ингэж байж бас энэ уурхай, энэ компани өөрөө ашигтай ажиллах, олон жил Монгол улс үр ашгийг нь хүртэх боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа юм.

Энэ ноогдол ашигтай холбоотой асуудал ТУЗ шийддэг байж болно, Засгийн газар шийддэг байж болно. Тэгэхдээ цагаан дээр хараар бичсэн тэр хууль эрх зүйн хүрээнд асуудлыг шийддэг байх ёстой юм. Би ойлгож байгаа. Түрүүн хэлсэн шүү дээ, шинэ үйлдвэрлэлүүд технологийн шийдлүүд гарахад хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж. Хэрэгтэй зэрэгцээд бас хувьцаа

эзэмшигчдийн эрх ашгийг зөрчихгүй байх нь бидний үүрэг. Тэгэхээр энэ тал дээр манай Эрдэнэс Таван толгойнхон бас санаачилгатай ажиллахыг хүсье. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Би нэг асуулт асуугаадахъя. Монгол Улсын Засгийн газраас шинэ сэргэлтийн бодлого хэрэгжээд явж байгаа. Дотроо эрчим хүчний сэргэлт нөгөө Таван толгойг дагасан дулааны станц маань хэзээ баригдах вэ, юунаас болоод гацаа үүсээд байна гээд. Ер нь Монгол Улс 2024 онд гэхэд эрчим хүчний дутагдалд орох ийм аюул нүүрлээд байж байна. Маш олон бүтээн байгуулалт явж байна. Тийм учраас Эрдэнэс Таван толгойн хүрэн нүүрсийг эдийн засгийн эргэлтэд оруулах хамгийн бололцоотой зүйл станц байж байгаа. Тэгээд энэ станцын бүтээн байгуулалт хэзээ эхлэх вэ? Ийм асуулт байна.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон асуултад хариулъя.

Ж.Ганбат: Таван толгойн станц яригдаад, бас ТЭЗҮ, тэр байришил, бүх юмнуудыг нь ингээд тэндээ тодорхойлчихсон юм байна билээ. Тэгээд өнгөрсөн оны 12 сард Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яамныхантай Таван толгойн удирдлагуд газар дээр нь ажилласан. Тэгээд энэ асуудлаар Таван толгойн станцыг яаралтай эхлүүлэх гэдэг ийм байдлаар Засгийн газар дээр яригдаж байгаа. Маргааш Засгийн газрын хурлаар энэ асуудал яригдаад, дэмжигдвэл ойрын үед Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Таван толгойн станцыг эхлүүлэх ажлыг Эрчим хүчний яам гол хариу хариуцаад, санхүүжүүлэгч болон хамтран оролцогчоор Эрдэнэс Таван толгой компани оролцохоор ийм байдлаар Засгийн газрын түвшинд яригдаж байгаа юм.

Т.Энхтүвшин: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Аубакир гишүүн, Батжаргал гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн.

Т.Аубакир: Эрдэнэс Таван толгойн БЭТ томилогдсоноос хойш хийсэн ажлын тайланг сонслоо. Гишүүд ч өөрсдийн асуултыг асууж, хариултуудаа авлаа. Захиж хэлэх ганц, хоёр зүйл байгаа юм. Зарим гишүүд байр сууриа илэрхийлж байна. 1072 хувьцаатай холбоотой, ноогдол ашиг тараах байдалтай холбоотой. Энэ дээр би бас саналаа хэлье гэж бодож байгаа юм. 1072 хувьцааг төвлөрсөн хадгаламжийн нэгдсэн төв дээрээс авчраад, нээлттэй арилжаанд оруулахад манай Монгол Улсын нийгэм эдийн засгийн сэтгэл зүй бэлэн байна уу, үгүй юу гэж. 2020 оны 9 сард тодорхой иргэдийн 1072 хувьцааг сургалтын төлбөр, эмчилгээний зардал, хүүхдэд шилжүүлэх байдалтай 1072 хувьцааг хэсэгчилсэн байдлаар эргэлтэд оруулж үзсэн л дээ. Одоо тэр 1072 хувьцаагаа тухайн үед 2020 онд өгчихсөн иргэд юу ярьж байна гэхээр, бид нар ерөөсөө тухайн үед буруу юм хийчихжээ. Энэ 1072 хувьцаа чинь ингээд ноогдол ашгаа өгөөд, цаашидаа энэ зах зээлийн үнэлгээ нь өсөөд ирэхэд бид нар ер нь хямдхан өгчихсөн юм байна шүү дээ гэдэг байдал бий болж эхэлж байгаа юм. Миний нөгөө нийгэм эдийн засгийн сэтгэл зүй чинь бэлэн байна уу, үгүй юж гэдэг чинь ерөөсөө яг л энэ л дээ. Ард иргэдийн ахуй амьдрал амаргүй байгаа. Өр зээл ихтэй байгаа. Үүндээ шахагдаад 1072 хувьцаагаа тодорхой тухайн үеийн сэтгэл хөдлөлөөр байдаг юм уу, үгүй бол ингээд зээл янз бүрийн юмандаа шахагдаад өгчихдөг.

Гэтэл Монгол Улсын энэ газар доорх баялгийн тэгш хуваарилалттай холбоотой нөгөө үндсэн зарчим чинь алдагдаад нөгөө 1072 хувьцааг

нээлттэй арилжааалагдаад эхлэхээр хэсэг бүлэг хүмүүс тухайн тэр хувьцааг аваад, энэ арилжаанд оролцож байгаа хүмүүс маань давуу байдал гэдэг юм уу, эдийн засгийн давуу байдлаа ашиглаад авчихдаг. Одоо жинхэнэ бид нарын 170 гаргаад нүүрсээ зарж байна, ямар сайхан юм бэ гэж байгаа юм чинь. Тухайн үед жинхэнэ концерт болох вий дээ. Тийм учраас 1072 хувьцааг нээлттэй арилжаалах нь яг өнөөдөр нийгэм эдийн засгийн сэтгэл зүй бэлэн биш байна гэж би үзэж байгаа юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 1072 хувьцааны ноогдол ашигтай холбоотой ер нь бол өнөөдрийн өөхнөөс маргаашийн булчирхай дээр гэж, тийм ээ. Өнөөдөр бид нар 100000 төгрөгийн ноогдол ашиг авах уу, үгүй бол баяжуулах үйлдвэрээ бариад бид нар нүүрсээ цаашидаа ашиг оруулж борлуулдаг бололцоог нь бүрдүүлээд ирээдүйд бид нар илүү ашиг авахаа бодох уу, үгүй юү гэдэг чинь өөрөө ухааны асуудал. Яах вэ 1072 хувьцааг хүн болгонд 100000 төгрөг өгөхөд, авсан нь баярлалаа гээд өгсөн нь үгүй, мөн сайхан юм боллоо шүү гээд өнгөрөх байх л даа. Гэтэл энэ чинь яг нөгөө классик утгаараа тухайн компанийн засаглал чинь, дээрээс нь энэ баялгийн тэгш хуваарилалтын гэдэг энэ төрийн нөгөө гүн гүнзгий бодлого энэ дээр алдагдана шүү.

Тийм учраас ноогдол ашиг өгөх гээд нэг их яарах хэрэггүй. Яах гэж бид нар БЭТ томилсон юм. Үр ашгаа бид нар үзэх ёстой. Тэвчээртэй хүлээх ёстой, дахиад 6 сараар сунгаад компанийнхаа засаглалыг сайжруулъя. Тэр баяжуулах үйлдвэрээ барих хэрэгтэй. Тэр Эрдэнэс Таван толгойгоос гарч байгаа замын асуудлыг янзлах хэрэгтэй. Замыг очоод үзэхэд засмал зам гэхээргүй болчихсон байж байгаа. Тээвэрлэлтийнхээ асуудлыг хувийн хэвшлийн компанийн тээврийн зардалтай ойртуулах,

түүнээс ч бага тээврийн зардлаар тээвэрлэх боломжийг БЭТ хайж олох хэрэгтэй. Компанийн засаглал гэдэг зүйл чинь өөрөө төр ч хамаагүй гүйж орж оролцоод байдаг юм биш.

Тийм учраас БЭТ-ийг Засгийн газар томилсон, цаашидаа хугацааг нь сунгах байх. БЭТ энэ дээр хичээгээд, зарим газар бол төрийн төмөр нүүрийг харуулах хэрэгтэй. Тэгж байж бид нар ирээдүйд сайн сайхан авах ёстой болохоос биш одоо байгаа нүүрсээ өмнөх удирдлагууд нь бол сорчилж хуваагаад дууссан. Баахан нууц гэрээ л гэсэн. Бөөн бантанг л цэгцлээд явж байгаа шүү дээ. Тийм учраас саяны хоёр асуудлыг одоо ярихад эрт байна гэж би үзэж байгаа юм. Баярлалаа. Саналаа хэллээ.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тийм ээ, энэ нүүрс тойрсон асуудалтай холбоотой олон зүйлүүд яригдаад, онцгой дэглэм тогтоогоод БЭТ ажиллуулаад, тэгээд гайгүй ажлын үр дүнгүүд байна. Түрүүн талархаж байгаагаа илэрхийлсэн, улам сайн ажиллах шаардлагатай. Би Ганбатаас ийм л юм хүсмээр байгаа юм. Та нэгдүгээрт, тэнд бүрэн эрхт төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж байгаа. Хоёрдугаарт, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа хүн. Тэгэхээр ерөөсөө энэ төрийн өмчтэй компаниудынхаа харилцааг зохицуулж байгаа эрх зүйн орчноо боловсронгуй болгох хүрээнд хуульд ер нь ямар, ямар заалт, нэмэлт өөрчлөлтүүд орох ёстой юм гэдэг нэг асуудлаа бодмоор байгаа.

Хоёрдугаарт энэ компанийн дотоод дүрэм, журам энэ бүхий л зүйл дээр ер нь ямар өөрчлөлтүүд орж байж, саяын таны очсоноос хойш хийгдээд тэр эмх цэгцтэй болсон юмнуудыг

тогтвортой хадгалаад явах тэр бололцоо боломж бүрдэх юм бэ гэдэг юмыг харах ёстой. Таныг ажиллуулсан ч, ажиллуулаагүй ч тэнд хүнээс үл хамаараад тэр дотоод дүрэм, журмаараа гэдэг юм уу, эрх зүйн зохицуулалтаараа сайн менежментийнхээ чиглэл рүү явдаг тэр нөхцөл боломжийг нь бид энэ хууль тогтоомжийнх нь хүрээнд бий болгож өгөх ёстой юм. Тийм учраас энэ талаас нь би илүү анхаарч ажиллаасай. Тэгэх юм энэ нь зөвхөн Эрдэнэс Таван толгой дээр ч биш, ер нь төрийн өмчтэй компаниуд дээр зөв менежментийн засаглалын эрх зүйн зохицуулалт тал руугаа чиглэгдсэн ийм үйл ажиллагаа болж хувирна шүү. Энэ бол бас таны тэнд очиж тодорхой хугацаанд нэлээн үр дүнтэй ажиллаж бас нэлээн цаг хугацаа нерв, оюун санаагаа зарцуулсны чинь л үлдэх гол зүйл энэ байх ёстой гэж би энэ талаас нь харж хэлмээр байна.

Томоохон, томоохон хөрөнгө оруулалтыг хийлгүй яах вэ байна, болдог юм. Гэхдээ бид хэд баяжуулах үйлдвэр ч гэдэг юм уу энэ юмнуудаа хийхдээ, түүнийг тэжээдэг эх үүсвэрүүд нь яг бэлэн үү гэдэг юмыг нэлээн сайн бодоорой. Би эрчим хүчний хэрэглээ тэр талаас чинь бас асуудал байгаа юм биш биз дээ гэдэг бодол байгаад байгаа юм. Тэр нь юмнуудыг сайн харах ёстой. Дулааны станцын чинь асуудал. Наад баяжуулах үйлдвэр хоёр чинь ер нь зэрэгцэж яваад аль, аль нь ашиглалтад ороход хоёр биеийгээ нөхөж хангаад явах ийм бололцоо бүрдэхээр харагдаад байгаа юм биш биз дээ гэдэг ийм санаа надад байгаад байгаа. Тэгээд энэ талынхаа юмыг нэгддүгээрт бодох ёстой юм гэж.

Хоёр дахь зүйл, энэ хувьцааны ногдол ашиг өгөх, өгөхгүйн тухай ярьдаг зүйл биш ээ. Үнэхээрийн компанийн засаглал нь боломжит түвшиндээ оччихсон тийм хариуцлагатай сайн

засаглал байж байгаа бол өгөх ёстой юмыг нь өгдөг байх ёстой. Тэгж байж хувьцаа эзэмшигч нар уг компанийнхаа үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцдог, илүү идэвхтэй менежмент хэрэгжүүлэх тэр чиглэл удирдлагаар нь хангадаг, хяналт үйл ажиллагаагаа явуулдаг ийм зүйл. 1 жилийн ноогдол ашиг өгөхгүйгээр ийм хөрөнгө оруулалт хийнэ гэдэг юм байхгүй. Угаасаа эрх зүйн хувьд. Хэрвээ өөр юм хийх гэж байгаа бол хийж байгаа юмандаа улсуудын тэр ноогдол ашигт ноогдож байгаа мөнгөн дүнгээр нь ёстой үнэт цаасыг нь гаргаж давхар өгөх ёстой. Тэгж давхар үнэт цаас эзэмших эрхийг нь бий болгох ёстой. Тэгж хөрөнгийг татдаг болохоос биш өгөх ёстой юмыг нь хаачаад, түүгээр нь юм хийчхээд дараа жилүүдийн ашиг үр өгөөжөөр илүү их юм очно та нарт гээд суудаг тийм эрх зүйн зохицуулалт гэдэг юм уу, тийм менежмент оролцооны үйл явц гэж байхгүй.

Тийм учраас үүнийг энэ талаасаа илүүтэй харах ёстой. Би хүнд өгөх, өгөхгүйн тухай яриагүй байна. Хэрвээ өгөхөөр юм ноогдчихсон байгаа бол түүнийг нь буцаагаад ямар байдлаар ашиглах вэ. Тэр улсад нь яг.

Т.Энхтүвшин: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Яг жилийн өмнө яг санаж байна. Ганхуяг захирал орж ирээд Байнгын хороон дээр мэдээлэл хийж байсныг. Бас л яг Таван толгой компани ямар их ашигтай ажиллаж байгаа тухай, кокс химийн үйлдвэр байгуулах гээд судалгааны ажлууд хийгдэж байгаа тухай. Ер нь маш л тийм гоё санхүүгийн үзүүлэлтүүдийн тухай ярьж байсан. Тэгээд ямар их асуудал хуримтлагдчихсан байв аа. Өнөөдөр бас их л тийм сайн, сайхан санхүүгийн үзүүлэлтүүд явж байна. Цаад талд нь өр зээл, тэр улс шиг

төсвийн алдагдлын тухай олон зүйлүүд энд яваад байгаа. Үүний яг уг шалтгаан нь явсаар, явсаар байгаад энэ шууд төрийн өмчит хаалттай. Засгийн газрын улс төрчдийн заавраар асуудал шийдэгддэг. Тэр хаалттай системд л олон асуудлууд байгаад байгаа юм

Одоо ч гэсэн яг энэ хаалттай систем, яг энэ чигээрээ үргэлжилж байна гэж харж байна. Дахиад дээрээс нь, хэт их улс төрөөс хамааралтайгаас болоод яг бизнесийн компанийнхаа журмаар шийдвэрүүдээ гаргаж явагдахгүй. Тэр олон улсын санхүүгийн арга механизмуудыг, тэр урьдчилсан борлуулалтаас эхлээд миний сая харснаар Австралийн хөрөнгийн бирж дээр хамгийн оргил үнэ 2022 оны 9 сард байж, сүүлийн 6 сар бараг тогтвортой бууж байгаа юм байна. Нүүрсний үнэ. Нүүрсний үнэ өндрөөс доош бууж байхад бид нар ерөөсөө урьдчилж юм зарахгүй, урьдчилж гэрээ хийхгүй гээд суудаг чинь зүгээр л энэ өөрсдийгөө аргацаасан, олон нийтийн санаа бодол болоод улс төржилтөд тааруулсан л үг шүү дээ. Нүүрсний үнэ өнөөдөр өндөр байхад бид нар бас урьдчилсан үнэхээр тэр санхүүгийн арга механизм механизмыг болоод бусад зүйлсийг ашиглах ёстой шүү дээ. Тэгэхээр энэ компанийн менежмент болоод олон зүйл, тэр алсын хараа явж байгаа процесс, олон зүйлүүд хэтэрхий улс төрөөс, хэтэрхий төрөөс, хэтэрхий их улс төрчдөөс хамааралтай яваад байгаа. Үүний цаана асар их хэмжээний эдийн засгийн боломж бололцоог алдаж байгаа ийм нөхцөл байдал яг энэ Эрдэнэс Таван толгой дээр үргэлжилж байна. Мэдээлэл бас хаалттай. Сурталчилсан мэдээллүүдийг өгдөг. Яг л нөхцөл байдал. Магадгүй дараа жилийн Байнгын хорооны хурал дээр, дараа жил дахиад л өөр. Өнгөрсөн жил хэрхэн юм завхруулсан тухай ч юм яриад сууж байх ийм нөхцөл байдал яг хэвээрээ

үргэлжилж байгаа юм байна гэж харж байна.

Тэгэхээр энэ дээр илүү том хэмжээний өөрчлөлтүүдийг тэр олон нийтийнх болгох, нээлттэй болгох, мэдээлэл хаалттай биш байдаг. Дахиад олон улсын тэр санхүүгийн арга механизмуудыг ашигладаг. Ердийн энэ ашигтай ажиллах ёстой бизнесийн компани гэдэг энэ утга руугаа орох шаардлагууд үнэхээр бас энд үүсчихсэн, бүх зүйл хэвээрээ байна гэж би хувьдаа тийм л дүгнэлттэй энэ тайланг сонслоо.

Т.Энхтүвшин: Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн тайланг Үйлдвэржилтийн байнгын хороо сонслоо. Ер нь бид нар онцгой дэглэмээ цаашидаа үргэлжлүүлээд Засгийн газрынхаа бүрэн эрхт төлөөлөгчийг үргэлжлүүлэн ажиллуулах нь шаардлагатай юм байна гэж үзэж байна. Засгийн газраас онцгой дэглэмийг үргэлжлүүлэн БЭТ-ийн хугацааг сунгах тогтоолыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж Засгийн газарт албан ёсоор чиглэл өгье, Байнгын хорооны. Ингээд мэдээлэл сонсож дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Дараагийн асуудал. Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны 2022 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Сангийн яамны мэдээллийг сонсоно.

Сангийн яамны ажлын хэсгийг оруулаарай. Байнгын хорооны хуралд оролцож байгаа ажлын хэсгийн нэрийг танилцуулъя. Сангийн яамны дэд сайд Мөнгөнчимэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир, Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгө

удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Молор байна.

Монголын Хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирал Алтай, Монголын Хөрөнгийн Биржийн Төрийн өмчит хувьцаат компаний Үйл ажиллагааны газрын захирал И.Жавхлан.

Үйлдвэржилтийн байнгын хорооны 2022 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Сангийн сайдын мэдээллийг Дэд сайд Мөнгөнчимэг тавина. Ажлын хэсгийн 2 номерын микрофон өгөөрэй.

С.Мөнгөнчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Үйлдвэр үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 10 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний талаарх мэдээллийг та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар:

Байнгын хороон дээрх тогтоолоор Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр баталсан төрийн өмчийн хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдаалах үндсэн чиглэл батлах тухай 16 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэхийг чиглэл болгосон билээ.

Энэхүү чиглэлийн хүрээнд өнгөрсөн жил Сангийн яамнаас хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлдэг Төрийн банкны нийт хувьцааны 5.71

хувь, Монголын Хөрөнгийн биржийн хувьцааны 34 хувийг тус тус олон нийтэд нээлттэй худалдах ажлыг амжилттай зохион байгуулсан бөгөөд үндэсний давхар даатгал компанийн нийт хувьцааны 20 хувийг олон нийтэд нээлттэй санал болгох бэлтгэлийг бүрэн хангаад байна.

Урьдчилсан тооцоогоор үндэсний давхар даатгал компанийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн зохион байгуулахаар төлөвлөж байна. Ингэснээр Сангийн яамны хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг, олон нийтэд нээлттэй санал болгох ажлыг удирдан зохион байгуулсан 3 хуулийн этгээд нээлттэй ХК болж тус яамны хувьд Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдах юм.

Хоёрдугаарт, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан худалдах ажлын хэрэгжилтийн талаар:

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 10 дугаар тогтоолоор уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан худалдах эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотой хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг чиглэл болгосон. Энэ хүрээнд Засгийн газраас өргөн мэдүүлсэн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаас хэлэлцээд 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталсан бөгөөд хуулийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс дагаж мөрдөх юм.

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Засгийн газраас 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг Монголын Хөрөнгийн биржээр

гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд 2023 оны 2 дугаар сарын 9-ний өдөр нүүрсний анхны нээлттэй цахим арилжааг амжилттай зохион байгуулсан болно. Өнөөдрийн байдлаар Эрдэнэс Таван толгой компанийн 416000 тонн, Таван толгой ХК-ийн 236.8 мянган тонн, Энерджи ресурсес компанийн 172.8 мянган тонн, нийт 458.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 825.6 мянган тонн нүүрсийг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулж нээлттэйгээр арилжсан байна. Эрдэнэс Таван толгой компани өмнө нь олборлосон нүүрсээ аман нөхцөлөөр тонн тутмыг нь 100-115 ам.доллароор борлуулж байсан бол биржээр дамжуулан нээлттэй арилжсанаар анх удаа хил нөхцөлөөр тонн тутмыг 178-182 ам.доллар хүргэн борлуулсан, анх удаа эрчим хүчний нүүрс экспортлосон, Энерджи ресурсес компанийн баяжуулсан коксжих нүүрсний үнэ 13.6 хувиар өсөж тонн тутамд 206.7 ам.доллар хүрсэн зэрэг эерэг үр дүнгүүд гарсан болно.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр зөвхөн нүүрс төдийгүй алт, зэс, мөнгө зэрэг бусад уул уурхайн бүтээгдэхүүн биржээр арилжаалагдахаас гадна эдгээр бүтээгдэхүүнд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслүүд мөн биржээр арилжаалагдах юм. Үүнтэй холбоотой бэлтгэл бэлтгэл ажлыг Засгийн газрын холбогдох байгууллагууд тухай бүрд нь ханган ажиллаж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Т.Энхтүвшин: Дэд сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Батлут гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Монголын Хөрөнгийн биржтэй холбоотой бас л

болж байна. Энэ шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд бид нар чинь бас уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр нээлттэй арилжаалах ингэснээр далд явдаг байсан нүүрсний үнийн асуудлыг цэгцэлж гаргаж ирлээ.

Хоёрдугаарт, Монголын Хөрөнгийн биржийг өөрийг нь бас нээлттэй болгох ажил бол амжилттай явсан. Хувьцааны үнэ тодорхой хэмжээнд өсөөд явж байгаа_ Энэ бол эцсийнхээ зорилгодоо хүрэх ёстой. Бид нар ингээд нэг шийдвэр гаргачхаад, тэр болохгүй юм байна, энэ болохгүй юм байна гээд бас ухарч болохгүй л дээ. Тодорхой хугацаанд бид нар алдаа, оноо гарч байж үр дүнд хүрдгээс хойш. Тэгээд 2 асуулт байна.

Нэгдүгээрт, 34 хувь байх аа. Танай Хөрөнгийн биржийн 34 хувийг нийтэд арилжаалсан. Энэ Монголын Хөрөнгийн биржийн 34 хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид маань танай ТУЗ-д орж байгаа юу? Би яагаад үүнийг асуугаад байна гэхээр тэр хүмүүс чинь тодорхой хэмжээнд мөнгөө төлөөд хувьцаа авсан юм бол компанийн засаглалд оролцох эцсийн зорилготой байгаа. Энэ 7000 гаруй иргэн, аж ахуйн нэгж хувьцааны арилжаанд оролцсон гэж би мэдээлэл авсан. Манай тойрог дээрээс ч гэсэн багагүй хүмүүс энэ Монголын Хөрөнгийн биржийн хувьцааг авсан юм байна билээ. 100 төгрөгөөр арилжаасан, 160 төгрөгтэй 60 хувийн өсөлттэй явж байгаа юм. Бид нар энэ засаглалд оролцохгүй бол бид нарын хувьцаа авсны хэрэг юунд байгаа юм бэ гэж. Түүрүүн Батлут гишүүн хэлж байна билээ. Бид нар хууль дүрмээ мөрдөх ёстой, хувьцаагаа арилжаалсан юм бол тэр хүмүүсийг ТУЗ-д нь буюу энэ компанийн засаглалд орох бололцоог нь хангаж өгөх ёстой.

Тийм учраас танай ТУЗ-д чинь ямар хүмүүс байгаа юм. Хувьцаа

эзэмшигчдээсээ ТУЗ-д оруулах бодолтой байгаа юу гэсэн нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт маань, Монголын Хөрөнгийн биржээр арилжаалагдаж байгаа нүүрс ч бай, IPO гаргаж байгаа компаниуд ч бай, энэ IPO гаргахад ихэнх зардлыг нь танай шимтгэл эзэлдэг. Ихэнх зардал юу байх вэ. Ер нь чамлахааргүй ийм мөнгө шимтгэлд нь төлдөг. Энэ шимтгэлийг бууруулах бололцоо байгаа гэж би харж байгаа юм. Энэ маань танай дэд бүтцийг сайжруулах, энэ шимтгэлийг багасгах хүрээнд орон тоо, гарч байгаа зардлууд нь миний авсан мэдээлэл бол бирж бол 0.14-0.15 хувь, клирингийн төв нь 0.12-0.24, үнэт цаасны хороо 0.1 гэж. Энэ шимтгэлийг багасгах талаар энэ арилжаанд оролцогчид их сонирхлоо илэрхийлдэг. Би эндээс ямар гарц харж байна гэхээр энэ Монголын клирингийн төв гээд нэг сул байгууллага байгаад байгаа юм. Энэ Хөрөнгийн бирждээ байна уу, эсвэл энэ Сангийн яамдаа байгаад байна уу. Эдгээр бүтцүүдийг нь бид нар эргэж харахгүйгээр зардлыг хэмнэж чадахгүй.

Энэ төрийн байгууллагууд, энэ төрийн сегментүүд оновчтой, зохион байгуулалттай, зардал хэмнэсэн байх ёстой үндсэн зарчим. Тийм учраас Жавхлан сайд байхгүй байгаа юм байна. Дэд сайд байгаа юм байна. Хэрвээ Сангийн яам дээр энэ Монголын клирингийн төв хэрвээ хамаарагддаг юм энэ Хөрөнгийн бирж рүүгээ нэгтгэж өгөх хэрэгтэй шүү дээ. Тэгж байж арилжааны энэ шимтгэл буурна. Мөн үүнтэй адилхан олон энэ шимтгэлийг бууруулах бололцоо бий. Шимтгэл буурснаар тухайн арилжаанд оролцогчдын сонирхол л нэмэгдэнэ. Одоо энэ банкны IPO нь гарч байна. 14-нд ХААН банкных гарах байх. Сая энэ Монголын Хөрөнгийн бирж гарсан. Голомт банк зэрэг. Мөн нүүрсний арилжаанд оролцож байгаа хүмүүсийн

тэр шимтгэлийг бууруулах гарцын нэг бол Монголын клирингийн төвийг Монголын Хөрөнгийн биржийн бүтцэд оруулж бололцоо бий юу гэсэн ийм хоёр асуулт байна.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

С.Тулга: Аубакир гишүүний асуултад хариулъя. Эхлээд 2 дугаар асуултаас нь эхлээд хариулаад явчихъя. Хоёрдугаар асуултын хувьд болохоор бид нарт 2 сонголт байгаа юм. Нэг бол бүх биржүүд нь дундаа 1 клирингтэй байна аль эсхүл бирж болгон нь өөр, өөртөө клирингтэй байгаад ингээд явах ийм 2 сонголт байгаа. Клиринг бол Сангийн яамны харьяа 6 компанийн 1-д харьяалагддаг. Сангийн яам яамнаас барьж байгаа бодлого нь бүх биржүүд нэгдсэн байдлаар энэ клирингийн үйлчилгээ аваад, ингээд явъя гэсэн ийм бодлого бариад явж байгаа. Тэгэхдээ гишүүний саналыг би хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулъя.

Эхний асуудал дээр одоогийн байдлаар ТУЗ Сангийн яамнаас 3 гишүүн байгаа, Монголбанкнаас 1 гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооноос 1 гишүүн гээд ингээд ердийн гишүүдтэй. Тэгээд 3 хараат бус гишүүнтэй ийм байдлаар үйл ажиллагаа эрхлээд явж байгаа. Уул уурхайн биржийн тухай хууль 7 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр Засгийн газраас нэгэнт уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг Хөрөнгийн биржээр зохицуулна гээд шийдвэр гаргачихсан тул Хөрөнгийн биржийн ТУЗ-ийн гишүүд бүгд нээлттэй сонгон шалгаруулалтад орох юм. 4 сарын 28-ны өдөр бид нар бас хувьцаа эзэмшигчдийнхээ хурлаа хийнэ. Энэ хурал дээр хувьцаат компани болсны анхны хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийнэ. Энэ дээр бид нар энэ асуудлаа танилцуулаад явна. Тэгэхлээр

34 хувийн хувьцаа эзэмшигчдээс нэгдэл үүсгээд ТУЗ-д гишүүнээ оруулах бүрэн боломжтой.

Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар хязгаарлагдаж байгаа асуудал болохлоор 5 хувиас доош хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч маань ТУЗ-д гишүүнээ оруулах боломжгүй байгаа. Тэгэхлээр Хөрөнгийн биржийн хувьд нэгэнт 34 хувь гаргачихсан юм чинь, 34 хувьд байгаа гишүүд нь нийлээд нэг хүнээ томилоод, ТУЗ-д ингээд сонгох ийм кумулятив аргаар сонгогдоод явах учраас энэ боломж нээлттэй.

Т.Энхтүвшин: Аубакир гишүүн тодруулъя.

Т.Аубакир: Би өнөөдрийн энэ Байнгын хорооны хуралдаан дээр энэ 2 асуудлыг би санал болгож оруулмаар байгаа юм. 34 хувийг арилжаалсан бол тухайн тэр хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангаж өгөх хэрэгтэй. Тэгж байж энэ Засгийн газрын яриад байгаа Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төрийн өмчит компаниудын засаглал сайжирна гэж би үзэж байгаа юм. Энэ онолд би итгэдэг хүн.

Тэгэхгүйгээр төрийн албанаас аваачаад ТУЗ-д тавиад байх юм бол бид нар 30 жил харлаа шүү дээ. Юу боллоо тийм ээ. Тийм учраас өнөөдрийн хуралдаан дээр би энд Хөрөнгийн биржийн ТУЗ-ийг энэ хувьцаа эзэмшигчдээс нь оруулах нь зөв гэдэг нэгдүгээр санал.

Хоёрдугаар санал, сая энэ Клирингийн төвийг Монголын Хөрөнгийн биржид бүртгэх. Та бас худлаа мэдээлэл өгөөд байна. Одоогийн манай энэ брокер, хөрөнгийн бирж бол өөр дээрээ клирингтэй байгаа шүү. Зөвхөн Монголын Хөрөнгийн биржээс

шимтгэл аваад амьдарч байгаа. Нэгэнт тийм юм бол энэ чинь бие даасан байх ямар ч хэрэггүй шүү дээ. Танай Сангийн яамныхны ярьдаг төсвийг хэмнэе гэдэг бодлого чинь энэ дээр алдагдаад байгаа байх. Тийм учраас би энэ хоёр саналыг дарга албан ёсоор.

Т.Энхтүвшин: Хариулах уу, санал уу наадах чинь. Ганбаатар гишүүн. Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

С.Ганбаатар: Би маш тодорхой юм асуучихъя. Нөгөө Монголын Хөрөнгийн биржээр энэ Оюутолгой байна уу, энэ олон улсын томоохон компаниуд байна. 10 хувь нь Монголын биржээр зарагдана гэсэн нэг хуультай байгаа. Тэр Хөрөнгө оруулалтын гэрээн дээрээ түүнээс зайлсхийгээд оруулчихсан байгаа байх л даа. Тэр хуулийн хэрэгжилт ер нь ямар шатандаа явдаг бол. Тэр талаар та нар байр сууриа хэлээч. Тэр Оюутолгойн бууны нохойнууд боорлосоор байгаад, тэр үед Содхүү гуай Хөрөнгийн биржийн даргаар байсан. Маш зөв заалт оруулсан. Боорлосоор байгаад, доромжилсоор байгаад тэр Баабар тэргүүтэй улсууд тэгээд новшруулаад, яг л эх орноосоо урваад ингээд алаад хаячихсан. Тэгээд тэр хууль нь байдаг, ямар шатдаа явдаг бол?

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон өгөөрэй.

И.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Маш зөв зүйтэй асуулт. Ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйл дээр энэ заалт байдаг. Стратегийн ордын 10 хувийг Монголын Хөрөнгийн биржээр арилжина гээд. Монголын Хөрөнгийн биржийн зүгээс бид нар ялангуяа энэ Оюутолгой компанийн 66 хувийг эзэмшдэг Туркой Зилл компани давхар бүртгэл хийлгээч Монголын Хөрөнгийн

бирж дээр хувьцаагаа гаргаад, монгол төгрөгөөр монгол иргэд худалдаж авах тэр боломжийг нээж өгөөч гэсэн. Тэр асуудлыг удаа дараа тавьж Рио Тинто, Туркой Зиллийн удирдлагуудтай уулзаж байсан. Энэ асуудал нэлээн тийм урагшлаад ажил хэрэг болох гэж явж байгаад харамсалтай нь Рио Тинто компанийн зүгээс Туркой Зилл компанийг Ньюйоркийн хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах ийм шийдвэр гараад энэ нь өөрөө удааширчихсан явж байгаа.

Гэхдээ энэ цаашидаа өөрөө хэрэгжээд явах нь зөв зүйтэй зүйл гэж бидний хувьд үзэж байгаа. Бусад Монголд үйл ажиллагаа явуулдаг гаднын хөрөнгийн биржүүд дээр хувьцаагаа гаргасан 20 орчим компани байдаг. Эдгээр компаниудыг бол давхар бүртгэл хийж манай Монголын Хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргаач гэсэн таниулах уулзалт, энэ асуудлыг Хөрөнгийн биржээс тогтмол тавиад явдаг. Энэ ажил хэрэг болох ёстой. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль дээр үүнтэй холбоотой давхар бүртгэлийн зохицуулалт байдаг.

Тэгэхлээр Монголын Хөрөнгийн бирж дээр монгол төгрөгөөр хувьцаагаа гаргаснаар монгол иргэд, Монголынхоо хөрөнгийн биржээс уул уурхайн баялгийн баялгийн өгөөжийг хүртэх энэ боломж нь бол шууд нээгдэнэ. Ер нь байгаа стратегийн ордуудын хувьд аваад үзэхэд Эрдэнэс Таван толгой жишээлбэл, Монгол улсын иргэн бүр хувьцаа эзэмшдэг. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр хувьцаа нь бүртгэлтэй байдаг. Багануур зэрэг хувьцаат компаниудын хувьцаа нь Монголын Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байдаг.

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Тэгэхлээр Монголын ард түмний баялгаар бий болж байгаа төсөл хөтөлбөрүүд шүү дээ. Төсөл хөтөлбөрүүд. Яг үндсэндээ Монголын Засгийн газраас өгсөн лиценз зөвшөөрлөөр мөнгө босгож байгаа. Тэгээд хувьцаа бий болгож байгаа. Энэ томоохон төслүүд Монголын Хөрөнгийн биржийг даваад, үл ойшоогоод дандаа гаднын хөрөнгийн биржүүд дээр гардаг. Тэгээд түүнийгээ манай хууль дээр ч байгаа. Стратегийн ордуудын 10 хувь нь Монголдоо байна. Тэгэхээр Монголдоо борлогдож зарагдана гэдэг. Тэгэхээр энэ дээр ганцхан Алтай захирал маань. Тэр хөрөнгийн бирж өөрөө зүтгээд санаачлаад байхаас илүү Их Хурал энэ Байнгын хороодууд энэ чинь хуулийн хэрэгжилтийг хангах ёстой байгууллага нь шүү дээ бид чинь уг нь. Бидэнд тодорхой саналууд оруулж ирж, шийдлүүд гаргаж.

Т.Энхтүвшин: Санал байна. 2 асуулт байна. Нэгдүгээрт нь, Биржийн тухай тухай хууль 7 сарын 1-нд хэрэгжиж эхэлнэ. 7 сарын 1-нд хэрэгжихтэй холбогдуулаад 32 журам гаргах ёстой. Энэ ер нь ямар шатад явж байгаа вэ. 7 сарын 1-нээс өмнө энэ журам гарч амжих уу.

Хоёр дахь асуудал, энэ АМНАТ-ын асуудал их яригдаж байгаа. АМНАТ-асуудал. Бид нар уул уурхайн бүтээгдэхүүнээ зарсан үнээр биш, цаад Хятадын үнээр АМНАТ төлж байгаа шүү дээ, дэлхийн зах зээлийн үнээр. Тийм учраас энэ АМНАТ-ыг биржээр бүтээгдэхүүнээ зарчихвал, энэ АМНАТ-аа биржийн үнээр төлж болох уу гэдэг асуудал байна.

Бид Хөрөнгийн биржийн нэр төрлийг цаашидаа ч гэсэн нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа. Энэ 7 сарын 1 гээд хууль хэрэгжээд ирэхээр, бүх хувийн хэвшлийн компаниуд биржээр баяжуулсан, боловсруулсан болон

түүхийн энэ эрдэс баялгаа заръя гэдэг ийм асуудал тавина. Өнөөдөр ингээд АМНАТ-ын төлбөр ингээж давж биеллээ гээд яриад байгаа шүү дээ та хэд. Энэ бол олборлож байгаа компанийн АМНАТ-ын төлбөр төлөгдөж байгаа болохоос биш яг үүнийг баяжуулж байгаа компаниуд АМНАТ-ынхаа төлбөрийг төлөхгүй байгаа. Төлөхгүй байгаа шүү. Амьдрал яг ийм байж байгаа.

Тэгэхээр биржээр энэ бүх хувийн хэвшилийн компаниуд энэ эрдэс баялгаа баяжуулсан болон боловсруулсан түүхий эдээ зарахад Хөрөнгийн биржийн хүчин чадал хүрэх үү.

Хоёрдугаарт энэ АМНАТ-ыг энэ биржийн үнээр төлөх үү гэдэг дээр хариулт хэлж өгөөч.

Дараагийн асуудал, энэ Аубакир гишүүний энэ ярьж байгаа асуудал зөв л дөө. Нэгэнт Хөрөнгийн бирж 34 хувиа олон нийтийн болгоод, хувьцаагаа олон нийтэд арилжаалаад, мөнгийг нь авчихсан бол тэр олон нийтийн хяналтыг ТУЗ-д оруулж ирэх асуудлыг яаралтай шийдчих хэрэгтэй. Тэгээд маш олон үр дагавар гарлаа шүү дээ. Төр өнөөдөр муу менежер гэдгээ бид нар харуулчихсан шүү дээ. Тэгээд олон нийтийн хяналттай болж байж цаашидаа энэ Хөрөнгийн бирж явна шүү. Цаашидаа ингээж олон нийтийн хяналттай болохгүй бол Хөрөнгийн бирж дараагийн алдааг давтаж, дараагийн луйвар, булхай бол Хөрөнгийн биржээр явах магадлал маш их өндөр байгаа шүү.

Тийм учраас энэ олон нийтийн хяналтыг ТУЗ-д оруулж ирэх ажлыг яаравчлан хийх хэрэгтэй. Бид нэг юман дээр их сайн анхаарах хэрэгтэй. Яагаад Монгол Улсад баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүд бий болохгүй байна. Яагаад Монголд энэ эрдэс

баялгаа баяжуулаад, боловсруулаад, нэмүү өртөг шингээж чадахгүй байна гэдгийг бид их сайн анхаарах хэрэгтэй. Энэ ерөөсөө АМНАТ-тай холбоотой, давхар АМНАТ-тай холбоотой. АМНАТ гэдэг бол ашигт малтмалын нөөцийг хэн ашигласны төлбөр. Ашигт малтмалын нөөцийг хэн ашигладаг вэ гэхээр, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа компани ашигладаг. Олборлоод АМНАТ-аа төлчихсөн компаниас дахиад нэг баяжуулах үйлдвэр нүүрс ч гэдэг юм уу, төмрийн хүдэр худалдаж аваад ингээд баяжуулаад дахиад АМНАТ төлдөг асуудал ийм давхар АМНАТ-ын асуудал ганихан Монголд байж байгаа юм.

Харин бид нар үүсмэл ордоос АМНАТ авах нь зөв. Тийм учраас энэ давхар АМНАТ-ын асуудлыг ер нь цаашидаа яаж шийдэх юм? Би Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга байгаа учир үүнийг яриад байна л даа. Ийм зүйлүүд дээр хариулт авъя. Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

С.Тулга: Энхтүвшин гишүүний асуусан эхний асуултад хариулъя. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хууль хүчин төгөл хэрэгжиж эхэлснээр Хөрөнгийн биржээс 11 журам, Санхүүгийн зохицуулах хорооноос 4 журам, Уул уурхайн яамнаа 1 журам гээд, олон дүрэм журмуудыг батлах шаардлагатай байгаа. Тэгээд Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, Клиринг, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж тэгээд Уул, уурхайн яамнаас хамтраад бид нар ажлын хэсэг байгуулаад тэндээ баг болоод ажлуудаа хувааж аваад ажиллаж байгаа.

Алтай захирал бид хоёр яг нөгөө биржийнхэн хийх ёстой журмууд дээр түлхүү анхаараад ингээд явж байгаа. Хүчин чадлын хувьд хүрэх үү гэж Энхтүвшин гишүүн асуусан. Мэдээж

уул уурхайн бүтээгдэхүүн түүнийг дагаад уул уурхайн бүтээгдэхүүн дагасан санхүүгийн үүсмэл хэрэгслүүд гээд зөндөө, өмнө бид нар хийж байгаагүй шинэ ийм сорилтуудтай тулгарч байгаа. Үүнтэйгээ холбогдуулаад манай ТУЗ-өөс биржийнхээ орон тоог 69 хүн болгож нэмэгдүүлсэн байгаа. Тэгээд дээрээс нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор ажилтнуудынх нь цалин хангамжийг нэмэх ийм асуудлуудыг ингээд шийдээд ерөнхийдөө хүчин чадал нэмэх асуудал дээр онцгой анхаараад ажиллаж байгаа.

Тэгээд 7 сарын 1-нээс өмнө ямар ч байсан бүх холбогдох журмуудаа боловсруулаад, чадахыг нь батлуулаад, чадахгүй зүйлээ гаднаас ноу, хау зээл тусламжийн хөрөнгөөр ч юм уу, зөвлөгөө авахаар ингээд ажиллаад явж байгаа.

Ж.Ганбат: Хоёрдугаар асуулт, АМНАТ-ын асуудал дээр, Уул уурхайн яаман дээр Ашигт малтмалын хуулийн өөрчлөлтийн шинэчилсэн найруулгын асуудлаар ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Энэ хүрээнд Уул уурхайн яам, Сангийн яам, Засаг дээр ямар асуудал яригдаж байгаа гэхээр, ер нь энэ ашигт малтмалын нөөцийн асуудлыг Ашигт малтмалын хуулиас салгаад тусдаа бие даасан хууль хууль болгоод явуулбал яасан юм бэ гэдэг ийм асуудал ярьж байна. Энэ хүрээндээ 7 сарын 1-нээс Биржийн хууль үйлчлээд эхэлнэ. Тэгэхээр бид ер нь цаашидаа энэ биржээр зарагдаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнээс АМНАТ авахдаа бирж дээр зарагдсан тэндээс нь тооцож авах нь зөв гэдэг ийм байр суурийг барьж байгаа. Үүний дагуу бас холбогдох хуулийн төслүүд, бусад юмнууд дээр нь ажиллаж байгаа.

Т.Энхтүвшин: Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Бямбадагва дарга хариулъя. 3 номерын микрофон өгөөрэй.

Б.Бямбадагва: Энхтүвшин даргын асуултад хариулъя. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өнгөрсөн оноос боловсруулаад, 3 сарын 1-нээс 4 сарын 1-ний хооронд олон нийтэд нээлттэй тавьсан байгаа. Энэ хугацаанд саналуудыг олон нийтээс авч ажиллаж байгаа. АМНАТ-ыг хуулийн төсөл дээр шаталсан хэлбэрээр авах зохицуулалтыг тусгасан байгаа. Үзэл баримтлалын хүрээнд 3 яамны түвшинд саналаа нэгтгээд 3 сайд баталчих юм бол дахин олон нийтэд нээлттэй тавьж, дахин саналуудыг аваад хууль тогтоомжийн хуулийн хүрээнд ингээд явах ийм төлөвлөгөөтэй яамны зүгээс ажиллаж байгаа.

Холбогдох журмуудын тухайд, хамгийн чухал асуудал, эхлээд Уул уурхайн биржийн тухай хууль хэрэгжихээс өмнө нэр төрлөө бид нар Засгийн газраар оруулж батлуулах ёстой. Нэр төрлийг овор ихтэй уул уурхайн бүтээгдэхүүнүүд дээр биржийн арилжааг зохион байгуулъя гэсэн ийм төлөвтэй байгаа. Эхний ээлжид нүүрсний түр журам ашиглагдаж байна. Төмрийн хүдэр, жонш, зэсийн баяжмал гэсэн ийм бүтээгдэхүүнүүд овор ихтэй бөгөөд хил үнээр тогтоход татвар авах нь боломжтой юм байна. Бусад алт болон үнэтэй металлууд бол Лондоны металлын бирж ч юм уу, бусад олон улсын зах зээл дээр зарласан үнээс татвар аваад явахад тээврийн зардал бага учраас харьцангуй гайгүй юм байна гэдэг ийм ойлголттой байгаа.

Тийм учраас нэр төрөл батлах энэ асуудал дээр ажлын хэсэг зохион байгуулаад ажиллаж байна. Сөн хамгийн чухал асуудал экспортлох журам байгаа. Энэ Уул уурхай, хүнд

үйлдвэрийн яамнаас боловсруулагдаад явна. Үүнтэй холбоотой бүтээгдэхүүнүүдийн стандартуудыг шинэчлэх асуудлууд нэн чухал тавигдана. Ялангуяа төмрийн хүдрийн баяжмал, жоншны гэсэн энэ стандартууд дээр одоогоор ажлын хэсгүүд ажиллаад явж байгаа. Өнөөдрийн байдлаар Биржийн түр журмаар явж байгаа учраас АМНАТ-ыг зарласан биржийн үнээс авч болохгүй байна. Тийм учраас хууль мөрдөх хугацаандаа буюу 6 сарын 30-наас хэрэгжих үед АМНАТ-ыг биржийн зарласан үнээс авах асуудлыг Сангийн яамтай ярьж байгаа. Манай Уул уурхайн яамны байр суурь үнэхээр эрүүл тогтолцоогоор зарласан биржийн үнээсээ АМНАТ аваач гэдэг ийм шаардлагыг тавьж байгаа юм.

АМНАТ-тай холбоотой асуудлуудыг ажлын шугамаар бас энэ хуулийн төсөл дээр ирсэн саналуудыг бас ярилцаж гишүүд та бүхэндээ танилцуулж болно.

Т.Энхтүвшин: Би Ганбат даргатай бас санал нэг байна. Уул уурхайн яамны бас хүмүүс байгаа учир. Энэ Ашигт малтмалын тухай хуулийг боловсруулахдаа энэ татварыг нь тусад нь хууль болгож батлах асуудал дээр онцгой анхаараарай. Тухайлбал Түгээмэл тархацтай төлбөрийн тухай хууль гэж байдаг. Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль гэдэг, Байгалийн ургамлыг ашигласны төлбөрийн тухай хууль гэдэгтэй адилхан АМНАТ-ийн тухай хууль гэж тусад нь хийхгүй бол ингээд Ашигт малтмалын тухай хууль өөрөө ингээд татварынхаа, төлбөрийнхөө асуудалтай хамт яваад байдаг хууль ганцхан л Ашигт малтмалын тухай хууль байгаа шүү дээ. Тийм учраас Ашигт малтмалын тухай хуулийн ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Энэ асуудал дээр бас тусад нь ингэж

хууль болгож оруулж ирвэл илүү их бас энэ аж ахуйн нэгж, байгууллагуудад ч гэсэн тодорхой болох болов уу гэж бодож байна.

Тэгээд биржтэй холбоотой асуудлаар түрүүн би хэлсэн. Үнэхээр зарагдсан биржээр нь АМНАТ-ыг тооцож авна гэх юм Монголд энэ уул уурхай эрхэлж байгаа болон боловсруулах, баяжуулах үйлдвэр хийж байгаа бүх хүмүүс танайхаар зарна. Тийм учраас одоогоос эхлээд бэлтгэл ажлаа сайн хангах хэрэгтэй. Хүн хүчээ, мэргэжлийн боловсон хүчнийхээ асуудал байр танхмынхаа асуудлыг ч гэдэг юм уу. Ингээд дараагийн асуудал, Хөрөнгийн биржийг энэ олон нийтэд таниулах, Монгол өөрөө Хөрөнгийн биржээр энэ эрдэс баялгаа зарж байгаа гэдэг энэ мессежийг дэлхийн улсуудад өгөх хэрэгтэй байна. Манай гол худалдан авагч ерөөсөө урд шүү дээ. Тийм учраас тэр Бээжинд нь ч байдаг юм уу, Шанхайд нь ч байдаг юм уу, тэр Сингапур, Хонконгод нь ч байдаг юм уу. Тэнд ямар томоохон хэмжээний арга хэмжээ болж байна, уул уурхайтай холбоотой. Тэнд мэдээ мэдээллээ бид нар өгөх, олон нийтэд энэ сигнал өгөх ажлуудаа хангалттай сайн хийх хэрэгтэй. Тэгвэл бид ганцхан Баяннуур гэхгүй, ганцхан Бугат гэхгүйгээр бид нар цаад талын эх газрын Хятад руу зарах тийм бололцоо боломж байж байна шүү дээ.

Тийм учраас мэдээ мэдээллээ бас ингэж сайн өгөх хэрэгтэй байна гэдгийг бас хэлмээр байна.

Ингээд Дэд сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Батлут гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр бид яах аргагүй үнэт цаасны хоёр дахь зах зээлийг хөгжүүлье. Банк санхүүгийн системээс бусад санхүүгийн салбараас хөрөнгө босгоё гэвэл яах аргагүй энэ үнэт цаасны асуудал, биржийн тухай асуудал гарч ирээд байгаа юм. Тийм учраас сая ингээд 34 хувь руу энэ олон нийтийн болгох үйл ажиллагаа явагдчихлаа. Тэгэхээр засаглалын ил тод нээлттэй байдал, үр өгөөж, хариуцлагын механизмууд мэдээж үүнийг дагаад бүрдээд ороод ирнэ гэж би ингэж ойлгож байна.

Тийм учраас энэ тал руугаа илүү анхаарч, бүтээлч ажиллах ёстой болов уу гэсэн нэг ийм бодол байна.

Хоёрдугаарт, энэ Монголын Хөрөнгийн биржийн нэр хүндийг өсгөө, нийт эргэлтийг нь нэмэгдүүлье гэвэл ижил төстэй гадаад улс орнуудын байгууллагуудтай, биржүүдтэй хамтарч ажиллах асуудлыг илүүтэй өргөн хүрээтэй бид хийх ёстой. Тэгж байж монголчууд тэр дэлхийн үнэ цэнтэй үнэт цааснуудыг эндээ Хөрөнгийн биржээрээ дамжуулаад эзэмших бололцоо боломж нь бүрдэх ёстой гэж ингэж харж байна.

Дараагийн нэг зүйл, манай энэ мэргэжлийн байгууллагууд нэлээн зөвлөмж чиглэлээр хангамаар байгаа юм. Энэ төрийн өмчтэй гэдэг юм уу, энэ аж ахуйн байгууллагуудыг ер нь энэ монопол маягийн хэлбэртэй компаниудын засаглалыг ч задлах тухай асуудал бидэнд байгаа юм. Сая банкны систем яг тийм хэлбэрээр явлаа шүү дээ. Тэгэхээр зэрэг 34 хувиас доош хувийг нь гаргах асуудал бол тийм ч их үнэ өртөг хүрдэг эд мөн юм уу, биш юм уу. Улсууд ер нь хяналтын багцтай байж, удирдах үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих боломж бүрдэнэ. Менежментийг сайжруулна, үр

өгөөжийг дээшлүүлнэ гэж бодож орж байгаа.

Тийм учраас бид үндсэндээ зарим тохиолдолд хоёрын хооронд хувь юмнууд гаргаад, тэр үнэ цэнтэй аж ахуйн байгууллага, элдэв юмнуудынхаа үнэ цэнийг унагаад байгаа юм биш биз дээ. Энэ чинь угаасаа хуулиар зохицуулчихсан тов тодорхой зүйлийг түүнд нь хүргэхгүй юм гаргачихаар зэрэг түүнд итгэж оролцдог оролцоо гэдэг юм уу, үнэ цэнийн асуудал буураад байгаа юм биш биз дээ гэдэг ийм зүйл байгаа. Тэгэхээр үүнийг нэлээн сайн судалж, бодож үзүүштэй ийм зүйл байна.

Ашигт малтмалын тухай хууль сая Байнгын хорооны дарга хөндсөн. Тэр дотор 2, 3 зүйлийг бид бодмоор юм байна. Нэгдүгээрт, энэ тусгай зөвшөөрлүүдийг банк санхүүгийн байгууллагад барьцаалдаг байх ёстой юм уу, эсхүл үнэхээрийн хөрөнгө мөнгө нь дутагдаад байгаа юм бол тэр эдийн засгийн баталгаатай ордуудаа, ТЭЗҮ элдэв бусын юмыг нь ил гаргаж тавиад, хөрөнгө босгодог үйл явцаараа явах ёстой юм уу. Тэгэх юм бол Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа илүү идэвхжих, өргөжих, анхнаасаа тэр бий болж байгаа том ордууд дээр заяагдмал баялаг дээр бий болж байгаа компаниуд өөрөө олон нийтийн засаглалтай болох бололцоо боломж нь бүрдэх ёстой гэж ингэж ойлгогдож байгаа.

Дээр нь энэ газар нутгийн бүрэн бүтэн байдал энэ бүх үйл ажиллагаа ч гэсэн үндэсний аюулгүй байдал талаасаа ч бодсон, тэр хөрөнгө босгодог хэлбэр нь илүүтэй зохилтой байж мэдэхээр ингэж харагдаад байгаа юм. Энэ талаас нь та нар бас нэлээн бодвол, ер нь энэ Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа илүүтэй өргөн хүрээтэй явах, тэр яах аргагүй дотоодоосоо гэдэг юм уу, бусад чөлөөт эх үүсвэрүүдээс

хөрөнгө босгох бололцоо түүн дээр тулгуурлаж том хөгжлийн бүтээн байгуулалтууд явах бололцоо боломжууд илүү бий болох л ийм.

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Орж ирж байгаа бүх юмыг нь шүүмжлэх өнгөөр харсангүй. Тэгээд дураараа л бол. Ер нь социал демократ нам эрх барьж байгаа шүү дээ, уг нь бол. Социал демократ нам эрх барьж байгаа тохиолдолд төрийн өмчийг хувьчлах тухай ер нь их болгоомжтой ярьдаг юм даа. Эцсийн эцэст төрийн өмчид буруу байхгүй шүү дээ. Төрийн өмчийг удирдаж байгаа улс төрчдийн тавиулуудын л буруу байгаа. Энэ засаглал дээрээ л уг нь ярих ёстой. Тэгэхгүй зүгээр тэгээд хувьчилчихъя гэдэг бол цаад утгадаа, энэ төрийн өмчөөс чинь хагартлаа идэж уусан улсууд буцаад хувь авна. Жирийн иргэд эндээс авах ямар ч вариантгүй. Социал демократ нам ингэж уг нь үздэггүй санагдаад байгаа юм.

Тэгээд би жишээ ярья. Бидний магтан дуулаад байдаг зэсийн хамгийн том ордууд болох Чилийн Коделко, яг төрийн өмчит шүү дээ. Төрийн өмчит хэвээрээ байгаа. Норвегийн томоохон энэ уул уурхайн компаниуд бүгд төрийн өмчит 100 хувь. Харин түүнийг удирдах менежмент дээр төр муу байж болно. Энэ нь цаад утгаараа төр өөрөө муу өмчийн эзэн гэсэн үг биш. Энэ 2 утгыг ингэж солбиж ингэж луйвар хийдэг. Таксыг төр өмч өмчилж болно, жолооч нь заавал төр өөрөө байх албагүй гэсэн санаа. Тэгэхээр онол ярилтай нь биш дээ. Тэгээд энэ дээрээ эргэж уг нь сайн бодоорой. Тэгээд нэгдүгээрт үүнийг яриад, санаандаа тунгаавал их буян болно.

Хоёрдугаарт, биржийн тухай их ярилаа, хөрөнгийн биржийн тухай

ярилаа. Хөрөнгийн биржийг хувьчилж болно, болно. 34 хувь нь хэлтэй амтай тэгээд хүмүүст өгсөн л бололтой. Үгүй, энэ биржээ яаж хүч оруулах вэ, яаж таргалуулах вэ гэдэг дээр төр өнөөдөр анхаарах ёстой шүү дээ. Биржийг чинь тоохгүй байна шүү дээ. Монголын ард түмний 100 хувь, тэдний хувь заяагаар, тэдний газрын доорх баялгаар баяжсан улсууд наад биржийг чинь тоохгүй байна. Төр шахаж энэ өөрийнхөө бирж рүү оруулах ёстой. Тэр ажлыг нь ганцхан Алтай захирал дээр лаахайдаад хаяж болохгүй. Энэ дээр Их Хурал, Засгийн газар, Байнгын хороод анхаарах ёстой. Энэ дээр санал оруулж ирэх ёстой байх л даа.

Энэ дээр онол ярилаа гэж битгий бодоорой. Эдийн засгийн түүх гээд бүхэл бүтэн бие даасан салбар бий болчихлоо шүү дээ. Түүн дээр анх бирж гэдэг юм, энэ хувьцаа гэдэг юмыг Адам Смит их эсэргүүцсэн. Харин Карл Маркс их дэмжиж байсан. Яагаад гэвэл нөгөө хөрөнгийн эзний эрх мэдлийг ард түмэнд өгнө гэж бодсон байх. Гэтэл яг нарийн яривал хөрөнгийн эзэд хамгийн их хождог. Тэгээд хоёр дахь миний хэлэх санаа гэвэл ингээд буруу, зөрүү замаар зөндөө явсан олигархууд байдаг. Би үндэсний бизнес эрхлэгчтэй нэг ч шүүмжилдэггүй. Гаднаас бас орж ирсэн луйварчныг би засаж залруулах гэж оролддог. Энэ хүмүүс Хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргах цаг болсон. Үүнийг төрөөс бодлогоор зохицуулалт хийдэг. ХААН банк, Эм Си Эс одоо эхэлж байх шиг байна. Үүний цаад утгандаа, яг тэр хөрөнгийн эздүүдэд ашигтай юм байгаа юм шүү дээ.

Нэгдүгээрт, улс төрчдөөс өөрсдийгөө хамгаалдаг, тэр ард түмний хувьцаа эзэмшигчдээр хамгаалуулдаг.

Хоёрдугаарт, эрсдэлээ хуваадаг. Хамгийн гол нь яриад байгаа тэр хяналт энэ дээр бий болдог.

Гуравдугаарт, би санаагаа хэлэх гээд байгаа юм нь гэвэл, эцсийн эцэст алт зэсийг тэр металлургийн биржээрээ явуулмаар байна шүү. Юун нүүрс. Нүүрсийн эцсийн хэрэглэгч ерөөсөө нүүрс бирж дээр оролцдоггүй. Алт, зэс авдаг. Лондонгийн металлын бирж дээр алт, зэс их явдаг юм шүү. Нүүрс бас л хэцүү дээ. Их бэрхиээлээр та нар даван туулж байгаа. Бүхэл бүтэн улс төр, эдийн засгийн бүлэглэл үүний эсрэг ажиллаж байгаа.

Т.Энхтүвшин: Аубакир гишүүн саналаа хэлье.

Т.Аубакир: Би түрүүн бас асуулт дээрээ хэлсэн. Бас нэг санал гаргаадахъя гээд. Энэ саяын Монголын үнэт цаасны клирингийн төвийн үйл ажиллагааг бас эргээж хараад арилжаанд оролцогчдын зардлыг бууруулахад түлхэц болно. Олон оролцогчтой болгохын тулд бас арилжааны шимтгэлийг бууруулах зорилго тавьж ажиллах ёстой. Арилжаанд оролцож байгаа IPO гаргасан нөхдүүдийн ярьж байгаа юм бол Хөрөнгийн биржийн шимтгэл өндөр байгаад байна гэж байгаа юм. Энэ шимтгэлд 0.12 хувь эзэлж байгаа. Монголын үнэт цаасны клирингийн төвийг шууд Монголын Хөрөнгийн биржийн бүтцэд оруулах нь хаашаа юм, Энхтүвшин дарга аа.

Энэ дээр би нэг санал боловсруулаад өгчихлөө. Манай редакцынхан найруулгыг нь хийж байгаад, миний саналыг энэ тогтоол дээр тусгаад өгөөдхөөрэй гэсэн энэ зүйлийг хэлэх гэсэн юм.

Т.Энхтүвшин: Батлут гишүүн.

Д.Батлут: Би түрүүн манай Байнгын хорооны даргын хэлсэн саналтай санал нэг байгаа. Тэгэхээр уул

уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах энэ шийдвэр гарч хуульчлагдаж, хэрэгжиж эхэлж байгаа нь маш сайн зүйл гэж харж байгаа. Монгол Улсын Засгийн газар энэ дээр маш сайн зохион байгуулалт хийж ажиллаж байгаа. Манай Монголын Хөрөнгийн бирж ч гэсэн энэ дээр маш сайн зохион байгуулалт хийж ажиллаж байгаад их талархалтай байгаа. Тэгэхдээ үүнийг дагаад бид нар олон асуудлуудыг шийдэх шаардлага байгаа юм. Өнөөдөр Монгол Улсын төсвийн тодорхой хувийг хувийн хэвшлийнхэн бүрдүүлдэг. Гэтэл уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг энэ хувийн хэвшлүүд, ямар их жаргал, зовлон байдаг вэ гэдэг талаар маш олон саналууд гаргадаг. Түүний нэг бол АМНАТ.

Өнөөдөр бид нар стратегийн хувьд ямар байришилд байгаа юм, байгалийн баялгаа борлуулах ямар орон зай боломжууд байгаа вэ гэдгийг бодох хэрэгтэй. Мэдээж дэлхийн олон улсын зах зээлийн үнээр борлуулах байгалийн баялаг байна, алт, мөнгө, зэс гээд. Гэтэл нүүрс ч гэдэг юм уу, жонш ч гэдэг юм уу агуулгын хувьд янз янз байдаг энэ бүтээгдэхүүнийг борлуулах нь өөрөө хязгаарлагдмал гэж гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ бүтээгдэхүүн борлуулах асуудал дээр бүтээгдэхүүнээс авч байгаа татварын хувь хэмжээг энэ уул уурхайн биржээр борлуулсан үнэ өртгөөс тооцдог болох ёстой. Ингэж гэмээнэ бид нар хувийн хэвшлээ дэмжсэн, тэтгэсэн, тэр цаашилаад бас хөгжиж, тодорхой хэмжээний далд эдийн засгийг ил болгох тэр боломжууд нэмэгдэнэ.

Ингэж ажиллаж байж энэ Уул уурхайн биржийн тухай хууль бүрэн утгаараа хэрэгжинэ гэж харж байгаа шүү. Тийм учраас би Байнгын хороон даргын гаргасан саналыг дэмжиж үг хэлж байна. Манай Сангийн яамныхан

байна, Хөрөнгийн биржийнхэн байна, Уул уурхайн яамныхан байна. Сайн бодож энэ асуудалд хандаарай. Ингэж байж бид бүхэн бас цаашаа ажиллаж амьдарна шүү. Монгол Улсын төсвийн тодорхой хувийг хувийн хэвшлийнхэн, тэр дундаа хувийн хэвшлийн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, компаниуд бүрдүүлж байгаа шүү. Тэднийгээ бид нар дэмжих биш, тэтгэх биш бүүр дарамтлаад байж болохгүй. Боломж бүхэн дээр бид нар дэмждэг, тэтгэдэг л байх ёстой. Ингэх нь Монгол төрийн үүрэг байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Сангийн дэд сайдын мэдээллийг сонсож дууслаа. Ажлын хэсэг байж байгаарай. Бас чиглэл өгөх тухай тогтоолын асуудал байж байгаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хороо Засгийн газрын гишүүний мэдээллийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тогтоол гаргаж болно гэж заасан байдаг. Үүний дагуу хөрөнгийн зах зээлийн талаар Сангийн сайдын мэдээлэл сонссонтой холбогдуулан **Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Гишүүдэд хүргүүлсэн байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу? Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

С.Ганбаатар: Дарга ийм байж болох уу. Тогтоолын төсөл дээр би түрүүний ярьсан хэдэн саналуудаа нэгэнт Засгийн газарт чиглэл өгч байгаа юм чинь. Энэ бирж хувьцааны тухай

яригдаж байгаа учраас түрүүн ярьсан тэр Ашигт малтмалын тухай хуулийн 6 дээр байгаа тэр стратегийн ордуудын 10 хувийг Монголын биржээр зарна гэдэг юмыг эрчимжүүлэх, үүнийг хуулийн хэрэгжилт дээр үр дүнтэй байлгах хэрэгжүүлэх талаар хүчтэйхэн шиг чиглэл өгмөөр байна. Нэгдүгээр санаа. Үүнийг 1.4 дээр оруулмаар байна. Яагаад гэвэл, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулаад дараагийн заалтад нь энэ заалт Ашигт малтмалын тухай хуулийн 6-гийн хэрэгжилтийг хангана гэдгээ оруулмаар байна.

Хоёрдугаар зүйл гэвэл, ер нь банкнууд болон энэ томоохон аж ахуйн нэгжүүдэд хувьцаагаа олон нийтэд арилжаалах тал дээр нь шахалт гэдэг үг оруулахгүй, дэмжиж тусалж, мэдээллээр хангаж, хамтран ажиллана гэдэг ийм 2 заалтыг оруулах хүсэл байна. Болох уу, боломж байна уу?

Т.Энхтүвшин: Болно, болно. Ганбаатар гишүүнд саналын хуудас өгөөрэй, та саналаа томъёолоод бичээд өгчих.

Ганбаатар гишүүнийг саналын томъёолол бичиж байх хугацаанд энэ Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төслийг та бүхэндээ уншаад танилцуулчихъя.

Тэгээд 1-ийн 4 дэх заалт болгоод Ганбаатар гишүүний томъёолол дээр санал хураагаад явъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.7, 23.2.14 дэх заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооноос тогтоох нь:

Нэг.Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны Засгийн газарт чиглэл өгөх тухай 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар хэлэлцээд, дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

1.Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдаалах Үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын Хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдаалах ажлыг эрчимжүүлэх. Мөн зах зээл дэх төрийн оролцоог багасгах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг ханган, засаглалыг сайжруулах зорилгоор хувьцааг нь олон нийтэд нээлттэй худалдаалах.

Төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

1.2.Хувьцаагаа нийтэд худалдсан төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийг эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, Монгол Улсын Их Хурлаас баталсан шинэ сэргэлтийн бодлогод нийцүүлэн, төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлын хэрэгжилтийг хангах.

1.3.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 7 сарын 1-нд хэрэгжүүлэхтэй холбогдуулан,

хуульд заасан холбогдох журмуудыг хууль хэрэгжих хугацаатай нийцүүлэн баталж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. Мөн биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл, экспортыг нэмэгдүүлэн, арилжааг олон улсын жишигт нийцүүлэн нээлттэй ил тод зохион байгуулах.

Хоёр.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга Т.Энхтүвшинд даалгасугай гээд ийм тогтоолыг гишүүдэд тарааж өгсөн байгаа.

Тэгээд Ганбаатар гишүүний саналыг, Аубакир гишүүний саналыг бас уншиж танилцуулъя. Зарчмын зөрүүтэй саналыг.

Аубакир гишүүний зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. Санал хураана.

Тогтоолд дараах агуулга бүхий 4 дэх заалтыг нэмэх. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Үнэт цаасны зах зээлийн байгууллагуудын бүтцийг цомхон болгох замаар хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлж, шимтгэлийг бууруулах, захиргааны зардлыг бууруулахыг дэмжих хүрээнд бодлого боловсруулж хэрэгжүүлэх. Ийм санал оруулсан байна.

Санал хураалт. Дэмжигдсэнгүй шүү.

Ганбаатар гишүүний санал байна.

Улсын Их Хурлын гишүүн Ганбаатарын зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 1.4-д, Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан стратегийн ордуудын тодорхой хувийг Монголын Хөрөнгийн биржээр арилжаалах хуулийн хэрэгжилтийг хангах. Ашигт малтмалын хууль. Ганбаатар гишүүн тайлбар хэлэх үү.

*Санал хураалт явуулъя.
Дэмжигдлээ.*

Ганбаатар гишүүний саналын томъёолол 54.5 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг бүхэлд нь дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Тогтоолын төсөл 54.5 хувиар дэмжигдлээ.

Өнөөдрийн Үйлдвэржилтийн байнгын хороогоор 3 асуудал хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийн хүмүүстээ баярлалаа. Хуралд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье.

17:05

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*